ДУНДГОВЬ АЙМАГ

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023.01.30 МАНДАЛГОВЬ ХОТ

| № | Зорилт, арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилт от түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Түвшин | | | |
| 1 | **Зорилго** Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагаа тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| 1.1 | **Зорилт** Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Улсын төсөв 2347.8 Хандив 20.9 | Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ (сая.төг) | 2020 | 105.2 | 435.0 | Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 2,347,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна. | 100 |
| 1.1.1 | **Арга хэмжээ:** Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх. | 2021-2024 | Улсын төсөв 140.0 | Эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтын хувь | 2020 | 81 | 83.9 | Улирлын томуугийн дархлаажуулалт 10 дугаар сараас эхлэн хамрагдаж эхэлдэг бөгөөд нийт хамрагдвал зохих зорилтот бүлгийн иргэдийн судалгааг гаргаж эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд хүргүүллээ. Нийт хамрагдвал зохих 9340 хүнээс эрсдэлт бүлгийн 8966 хүн хамрагдаж 96.0 хувьтай байна. | 100 |
| 1.1.2 | **Арга хэмжээ:** Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах. | 2021-2024 | Улсын төсөв 784.0 | Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2020 | 78 | 82.9 | Аймгийн хэмжээнд гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалт 90,3 хувьтай байна. | 100 |
| | | | Улсын төсөв 1400.0 | Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалтын хувь | 2020 | 50 | 55.8 | Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 3326 бүртгэгдсэн байна. 3326 тохиолдолд тандалт судалгааг хийн, хавьтлуудыг илрүүлэн хяналтад авч, түргэвчилсэн шинжилгээ болон баталгаажуулах шинжилгээнд хамруууллаа. Өнөөдрийн байдлаар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэрийн ажиглалтад ойрын хавьтал 12 хүн хяналтад байна. Коронавирусын халдварын тархалтын түвшин "Халдварын тархалт бага буюу ногоон" түвшинд байна. Томуугийн харуулдан тандалтын 2022 оны 45 дугаар 7 хоногийн мэдээгээр аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөл амбулаторийн үзлэгт 12,0%, дуудлагын үзлэгт 30,6%-тай байна.<br>Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалтын хувь 89.6 хувь байна. | |
| 1.1.4 | Арга хэмжээ: Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах. | 2021-2024 | Улсын төсөв 1.0 | Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо | 2020 | 50 | 55 | Гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээлэх дохиоллоор ажиллах дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны штаб, мэргэжлийн ангиуд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, газар хөдлөлтийн гамшгийн үеийн аврах ажиллагаа эмнэлгийн тусламжийн чиглэлээр дадлага сургалт хийлээ. Тухайн үйл ажиллагаанд нийт 82 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдаж, түргэн тусламжийн 3 авто машин цуглах талбайд бэлэн жагслаа. | 100 |
| | | | Улсын төсөв 0.4 | Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн тоо бүрэлдэхүүний тоо | 2020 | 1 | 2 | Эрүүл мэндийн албаны штаб, Мэргэжлийн ангийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, аранзны үзлэгт хамрагдан, мэргэжлийн 2 ангийг сурган дадлагажууллаа. | |
| 1.1.5 | Арга хэмжээ: Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх | 2021-2024 | ОНТ 3.3 | Нэвтрүүлсэн сургуулийн тоо | 2020 | 0 | 4 | 2021-2022 оны хичээлийн жилд 18 сургуулийн 4-5 дугаар ангийн 1000 сурагч тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ubt.mn цахим сайтын 3 удаагийн сорилд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамрагдаж анги дэвших болон улсын шалгалтад бэлтгэн оролцлоо. Элсэлтийн ерөнхий шалгалтын математик, хими, физик, монгол хэл, англи хэлний хичээлүүдээр бүрэн дунд боловсролын 8 сургуулийн 180 сурагчдыг elab.mn цахим сайтад хамруулан ажиллалаа. | |
| 1.1.6 | Арга хэмжээ: Багш нарыг зөөврийн компьютероор бүрэн хангах | 2021-2024 | Улсын төсөв 345.5 | Зөөврийн компьютероор хангагдсан багш нарын хувь | 2020 | 80 | 90 | Боловсрол, шинжлэх ухааны салбарын цахим орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлж ухаалаг самбар 17, принтер 17, проектор 17, зөөврийн компьютер 17, нийт 183 сая төгрөгийн 68 ширхэг тоног төхөөрөмжийг бүх сургууль, Насан туршийн боловсролын төвд хуваариллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Их соёл-Эх үндэс" төслийн хүрээнд 75 суурин компьютер 2022 онд шинээр нэмэгдсэн байна. Цэцэрлэгийн багш нарын зөөврийн компьютерын хангалт 95 хувь, ЕБСургуулийн багш нарын 496 буюу 93,4 хувь нь зөөврийн компьютероор хангагдсан байна. | 100 |
| 1.1.7 | Арга хэмжээ: Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт арга хэмжээнд хамруулах | 2021-2024 | Улсын төсөв 42.0 Дэлхийн банк 124.3 | Арга хэмжээний тоо | 2020 | 2 | 6 | ЕБС-ийн Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн улсын хэмжээнд багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа цахимд шилжиж Aplus платформд Боловсролын ерөнхий газраас зарласан 111 модулийн зорилтот болон сонголтод сургалтад аймгийн нийт багш нарын 93 хувь буюу 494 багш хамрагдан мэдлэг боловсролоо ажлын байрнаасаа дээшлүүлсэн байна. Дэлхийн банк, БШУЯ-аас хамтран хэрэгжүүлж буй "Сургуулийн тэтгэлэгт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөтөлбөр" төслийн хүрээнд цахим сургалт ашиглан цар тахлын үед сурлагын хоцрогдол арилгахад бага ангийн сургалтын үйл ажиллагааг сайжруулахад 18 чиглэлийн 124,3 сая хөрөнгө оруулалтыг хийж, төслийн хэрэгжилт 95 хувьтай байна. Мөн аймгийн 8 сургуулийн 10-р ангийн 163 хүүхэд сонгон хичээлийг цахим сургуулийн мэдлэ.мн платформоор судалж байна. Боловсролын салбарын цахим сургалт Teams системийг ашиглан бүх багшид үнэгүй эрхээр хандаж үйл ажиллагаагаа явуулж байна. Багшийн үр дүнгийн үнэлгээний үр дүн BI системээр улсын хэмжээнд big дататай болж, холбогдох удирдах ажилтан, багш нар үнэлгээг цахимаар хандан ашиглах боломж бүрдлээ. Сурагчдын сурах бичгийн хангалтыг ises системээр улсын хэмжээнд нэгтгэн түрээсийн сурах бичгээр хангаж байна. Энэ онд шинээр нийт 6 арга хэмжээг зохион байгууллаа. | |
| | | | | Багш, сурагчдын хамралтын хувь | 2020 | 55 | 65 | Хамрагдалтын хувь багш-93, сурагч 100 хувь | |
| 2 | **Зорилго** Хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| 2.1 | **Зорилго** Хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ. | | | | | | | | |
| 2.1.1 | Зорилт Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Улсын төсөв | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь | 2019 | 57.8 | 62.6 | 2022 оны байдлаар зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12078 иргэнээс 8694 буюу (72%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12974 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 18.2 Монпен төсөл<br><br>4.5 | | | | | иргэн хамрагдахаас 8662 буюу (66,7%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2568 иргэн хамрагдахаас 1610 буюу (62,6%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8449 иргэн хамрагдахаас 4993 буюу (59,1%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 65,1%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 68, чихрийн шижинтэй 9 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авлаа. | |
| 2.1.1.1 | <u>Арга хэмжээ:</u> Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулах | 2021-2024 | Улсын төсөв<br><br>1500.0 | Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо | 2019 | 0 | 1 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж 1,152,2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр ханган 347,8 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж ашиглалтад орууллаа. | 100 |
| 2.1.1.2 | <u>Арга хэмжээ:</u> Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, "Эрүүл мэндээ дээдлэгч иргэн", "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага"-ын тоог нэмэгдүүлэх. | 2021-2024 | Улсын төсөв<br><br>1.5 | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо | 2019 | 29 | 39 | Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу 2022 онд "Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрчүүдээ хайрлая", "Давсны хэрэглээгээ багасгая", "Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус", "Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя" зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 36670 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 25 удаа сургалт зохион байгууллаа. Иргэдэд эрүүл амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх зорилгоор "Илүүдэл жингүй Эртэч Монгол" 3 сарын аян, "Зөвийг хэвшүүлье" 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн 37679 иргэнийг хамруулан, мэдээлэл сургалт сурталчилгааг нийт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүн амын 82.3 хувьд хүргэлээ. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага", шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийн дагуу 2 материал ирүүлж, үнэлгээ хийж шалгаруулллаа. Ингэснээр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 38 болж нэмэгдэв.<br>Мөн "Эрүүл мэндээ дээдлэгч иргэн" шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийн дагуу идэвхитэй дасгал хөдөлгөөн, эрүүл зөв хооллолтыг дадал хэвшил болгосон 11 хүнийг шалгаруулллаа. Эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 44 боллоо. Нийт эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо 82 боллоо. | |
| 2.1.1.3 | **Арга хэмжээ:** Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах. | 2021-2024 | УТ 94.9 | Зорилтот бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалтын хувь | 2019 | 45 | 49 | Зорилтот насны иргэдийг хамруулах үзлэгийн үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлж 2022 оны байдлаар 6 бүлэг насны багцын үзлэгт 25300 хүн хамрагдахаас насанд хүрэгчдийн 4 багц үзлэгт 3790, 0-18 насны 2 багц үзлэгт 8958 хүүхэд тус тус хамрагдсан нь хамрагдвал зохих иргэдийн 48,5 хувийг эзэлж байна. | 87,5 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 2100.0 | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь | 2019 | 33 | 33.6 | Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-тай хамтран Хулд, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад дотор, эмэгтэйчүүд, ЭХО, уушги харшил, зүрх судасны цахилгаан бичлэг, оношилгоог алслагдсан сумын 3344 иргэдэд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Нийт үзүүлсэн иргэдийн 62,0 хувь нь | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ковидын дараах хам шинж, 29 хувь нь амьсгалын замын үрэвсэл, 10,1 хувь нь тоосны харшил, 9,7 хувь нь арьсны харшил, 32,5 хувь нь даралт ихсэх, 20,0 хувь нь цээжний бах, 23,9 хувь нь бөөрний үрэвсэл, 21,9 хувь нь нойр булчирхайн үрэвсэл, 19,67 хувь нь ходоодны архаг үрэвсэл тус тус оношлогдсон байна. Бөөрний хавдар 3-ийг илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ. Аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 34,2 байна. | |
| 2.1.1.5 | **Арга хэмжээ:** Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх. | 2021-2024 | Улсын төсөв 1700.0 | Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь | 2019 | 86.5 | 88.0 | Эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний төрлийн дагуу зайлшгүй шаардлагатай эм болон эмийн чанар аюулгүй байдлыг хангаан тасралтгүй хүртээмжтэй хүргэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүллээ. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зайлшгүй болон амин чухал эмийн хангалт 88,8 хувьтай байна. | 100 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 23.0 | Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь | 2019 | 82 | 84 | Төлбөрийг нь төр хариуцах эмийг 2022 оны байдлаар 7 оношоор 22 нэр төрлийн эм тариаг 605 хүнд 23.067.313 төгрөгийн эмийг олгоод байна. Нийт төлбөрийг нь төр хариуцдаг эмийг авах иргэнд 100 хувь олгоод байна. | |
| 2.1.2 | **Зорилт** Эхийн эндэгдэлгүй ажиллаж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | | Улсын төсөв 130.0 | Эхийн эндэгдлийн түвшин | 2019 | 0 | 0 | Жирэмсний хяналтын чанарын сайжруулах ажлын хүрээнд аймгийн төвийн 2 өрх, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг "Ажлын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна. | | Хандив тусламж 5.3 | | | | | байрны даддагажуулах 10 хоног"-ийн сургалтад цахимаар 2, танхимын сургалт 1 удаа тус тус хамруулаа. Жирэмсний хяналтад шинээр 575 жирэмсэн эх хамрагдсанаас жирэмсний эрт үеийн хяналт 93,2 хувьтай байна. Энэ жил нийт 555 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 94,6 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрж, жирэмсэн төрөх, төрсний дараах үеийн хүндрэл бүртгэгдээгүй. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. | |
| | | 2021-2024 | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ | 2019 | 10.8 | 10.4 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 7,2 промиль байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,2 промилиор буурсан үзүүлэлттэй байна. | |
| 2.1.2.1 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах | 2021-2024 | Хандив тусламж 5,3 | Эхчүүдийн амрах байраар амарсан эхийн тоо | 2019 | 194 | 270 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эхчүүдийн амрах байрыг 5,3 сая төгрөгөөр тохижуулж амрах байранд 33 эх амарч 296 ор хоног ашигласан байна. | 100 |
| 2.1.2.2 | Арга хэмжээ: 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх | | Улсын төсөв 2,0 | Чийрэгжүүлэлтэд хамрагдсан хүүхдийн тоо | 2019 | 0 | 4 | Аймгийн 0-5 насны нийт хүүхдийн 42,3 хувьд өсөлт хөгжилтийг тодорхойлж хоол тэжээлийн дутагдалтай хүүхэд бүртгэгдээгүй. Өндөршил, Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын Эрүүл мэндийн төвүүд зуны чийрэгжүүлэлтийн сувиллыг ажиллуулж, хоол тэжээлийн дутагдалтай нийт 5 хүүхдийг хэвийн жинд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.3 | **Зорилт:** Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ. | | Хандив тусламж 20,0 Улсын төсөв 2234,7<br>ОНТ<br>61,0 | Хэрэглэгчийн үнэлгээний хувь | 2019 | 91.5 | 92.6 | Аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 төрлийн нийт 2,234,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгогдож эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна. Нийт 1015 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэхэд эерэг үзүүлэлт 0,1 хувиар өсөж, муу үзүүлэлт 0,1 хувиар буурсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу QR код уншуулан иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч байна. Хэрэглэгчийн үнэлгээний сайн үзүүлэлт 93,0 хувьтай байна. | 100 |
| 2.1.3.1 | **Арга хэмжээ:** Нэгдсэн эмнэлгийг компьютер томограф, сумдыг мобайл технологиор хангах | | Улсын төсөв<br>60.0 | Мобайл технологиор хангагдсан сумын тоо | 2019 | 4 | 10 | Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгийн үнэ бүхий мобайл технологиор хангагдлаа. Ингэснээр 10 сум Мобайл технологиор хангагдаад байна. | 100 |
| 2.1.3.2 | **Арга хэмжээ:** Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх. | 2021-2024 | УТ<br>12000,1 | Нэр төрлийн тоо | 2019 | 11 | 14 | Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд 2021 оны 3 сараас эхлэн шилжиж, 14 нэр төрлөөр эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд 2022 оноос эхлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжлээ. | 100 |
| | | 2021-2024 | | Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь | 2019 | 84.0 | 89.5 | Гүйцэтгэлийн санхүүжилт 90,0 хувьтай байна. | |
| 2.1.3.3 | **Арга хэмжээ:** Хот хоорондын зам дагуух сумдын болон апслагдсан бүс нутгийн | 2021-2024 | Улсын төсөв 26,0 | Яаралтай тусламжийн цэгийн тоо | 2020 | 1 | 3 | Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулснаар авто осол 29, бусдад | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах. | | | | | | | зодуулсан 6, хугарал бэртэл 7, нохойд уруулсан 5, түлэгдэлт 6, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 5, угаартсан 1 мориноос унасан 2 зэрэг нийт 62 хүнд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлсэн. | |
| 2.1.3.4 | Арга хэмжээ: Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох | 2021-2024 | Улсын төсөв 20,9 | Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 45 | 46.7 | Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжид 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 20,9 сая төгрөгийн хандив тусламжаар олголоо. Яаралтай тусламжийн зөөврийн тоног төхөөрөмжийн хангалт 73%-тай байна. | 100 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 172,8 | Тоноглосон машины тоо | 2019 | 1 | 3 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 157,6 сая төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн иж бүрэн тоноглогдсон эмнэлгийн автомашиныг олгож, Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг нийт 15,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тоноглолоо. Тоноглосон машины тоо 5. | |
| | | 2021-2024 | Улсын төсөв 316.5 | Машины хангалтын хувь | 2019 | 90 | 93 | Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд Дэлгэрхангай, Луус сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 92,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 157,6 сая төгрөгийн иж бүрэн тоноглогдсон автомашин, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Эрдэнэдалай, Хулд сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 66,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Probox суудлын автомашиныг шинээр тус тус | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олголоо. Автомашины хангалтын хувь 98,3 хувьд хүрлээ. | |
| 2.1.3.5 | **Арга хэмжээ:** Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютероор хангах. | 2021-2024 | Улсын төсөв 0,4 | 2 догч шатлалын эмнэлгээс онлайнаар зөвлөгөө авсан тоо | 2019 | 0 | 20 | Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад утсаар 56 удаагийн нарийн мэргэжлийн зөвлөгөө өгч, 22 удаагийн цахим сургалтыг зохион байгууллаа. | 100 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 56.1 | Компьютерын тоо | 2019 | 15 | 39 | Эрүүл мэндийн газар, 15 сумын Эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 56,1 сая төгрөгийн үнэ бүхий суурин 24, зөөврийн 17, нийт 41 компьютероор хангагдсан. | |
| 2.1.3.1 | **Дэд зорилт** Эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Хандив туслам ж 20,0 Улсын төсөв 2234,7<br>ОНХС 61,0 | Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 85.0 | 85.9 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн үйл ажиллагаанд зориулан 1,152,2 тэрбум төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 370,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, "Хүнну ресорус" ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 2,5 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч тус тус олгосон. Мөн Зооноз өвчин судлалын төвд 14,6 сая төгрөгийн EliZa уншигч, гүн хөлдөөгч, 500,0 мянган төгрөгийн автомакс зэрэг тоног төхөөрөмжүүдийг олголоо. Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд биохими, бүрэн болон хагас автомат анализатор, 3 партын гематологийн анализатор, EliZa уншигч, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гүн хөлдөөгч, шүдний кресло/ком/, автоклав зэрэг 40 нэр төрлийн 644,7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 61,0 сая төгрөгийн, "Хүннү ресорус" ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг тус тус олгоод байна. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90,6 хувьд хүрлээ. | |
| 2.1.3.1.1 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих. | 2021-2024 | Улсын төсөв 8000,6 | Тухайн жилд шинээр барьсан эмнэлгийн барилгын тоо | 2019 | 0 | 1 | Тухайн жилд баригдаж буй аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгын ажлын гүйцэтгэл 96 хувьтай байна. | 96 |
| 2.1.3.1.2 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлгийн амбулатори, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилгуудад их засвар, Боржигон мандал, Өлзийт мандал, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийх. | 2021-2024 | Улсын төсөв 50,0 ОНТ 172,7 | Засвар хийгдсэн эмнэлгийн тоо | 2019 | 2 | 3 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөтгөх чиглэлээр "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт байгуулж 347,8 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж ашиглалтад орууллаа.<br>Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын засварыг 2023 оны төсөвт оруулахаар зураг төслийн үйл ажиллагаа бүрэн хийгдлээ. УАУ-ын төв, ЗӨСТөв, Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн барилгуудын их засварын хөрөнгийг 2024 оны төсөвт суулгахаар болсон. Улсын төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төв нь гадна талын тохижилтын ажил, орон нутгийн хөгжлийн сангийн 172,7 сая төгрөгөөр Эрдэнэдалай, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өндөршил, Баянжаргалан сумдын Эрүүл мэндийн 5 төв их засвар хийлээ. | 50 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Өргөтгөл хийсэн эмнэлгийн тоо | 2019 | 0 | 1 | Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл хийхээр хөрөнгийг 2023 оны төсөвт суулгахаар болсон. | |
| 2.1.3.1 .3 | **Арга хэмжээ:** Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах. | 2021-2024 | Хандив туслам ж 17,5 Улсын төсөв 644,7 ОНТ 61,0 | Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 78.5 | 78.9 | Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд биохими, бүрэн болон хагас автомат анализатор, 3 партын гематологийн анализатор, EliZa уншигч, гүн хөлдөөгч, шүдний кресло/ком/, автоклав зэрэг 40 нэр төрлийн 644,7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 61,0 сая төгрөгийн, "Хүннү ресорус" ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олголоо. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 88,5 хувь боллоо. | 100 |
| | | 2021-2024 | Хандив туслам ж 2,5 Улсын төсөв 2041,1 | Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 91.2 | 92.5 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн үйл ажиллагаанд зориулан 1,152,2 тэрбум төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 370,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, "Хүннү ресорус" ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 2,5 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч тус тус олгосон. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 92.6 хувь байна. | |
| 2.1.3.1 .4 | **Арга хэмжээ:** Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд | 2021-2024 | Улсын төсөв 0,8 | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай | 2019 | 52.4 | 68.2 | Эрүүл мэндийн байгууллагуудын дунд "Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай Эрүүл мэндийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх. | | | ЭМБ-ын эзлэх хувь | | | | байгууллага" болзолт уралдааныг зарласан бөгөөд 3 байгууллагаас материал ирүүлснийг хүлээн авч дүгнэлээ. Болзолт уралдааны урамшуулал, шагналыг 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр "Дэлхийн 00-ийн өдөр" гардуулан өгнө. Үүний үр дүнд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын эзлэх 80 хувьтай болсон. | |
| 2.1.4 | <u>Зорилт:</u> Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд 97.5 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Улсын төсөв 62,0 | Хүний нөөцийн хангалтын хувь | 2019 | 96.7 | 96.8 | Хүний нөөцийн хангалт 2022 оны байдлаар 96,8%-тай байна. | 100 |
| 2.1.4.1 | <u>Арга хэмжээ:</u> Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах | 2021-2024 | Улсын төсөв 50,0 | Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь | 2019 | 41.8 | 42 | Эрүүл мэндийн салбарт энэ оны байдлаар нийт 602 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд гэрт 281 буюу 46.6%, орон сууцанд 274 буюу 45.5%, бусад нөхцөлд 7.9% нь амьдарч байна. Дэлгэрцогт, Говь-Угтаал, Өндөршил, Цагаандэлгэр, Адаацаг сумдад ажиллаж байгаа нийт 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд орон сууцны асуудлыг шийдвэрлэн ажиллуулж байна. Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь 45,5-тай байна. | 100 |
| 2.1.4.2 | <u>Арга хэмжээ:</u> Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх. | 2021-2024 | Улсын төсөв 12,0 | Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь | 2019 | 94 | 94.9 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нарийн мэргэжлийн 71 эмч ажиллахаас одоогоор 68 ажиллаж хангалт 95.8%-тай байна. Хэрэгжилт 100% байна. | 90.6 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 6,5 | мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо | 2019 | 8 | 24 | Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд их эмч 4, сувилагч 4 төгсөн ирж сумдад ажиллаж байна. Нэн шаардлагатай нарийн мэргэшлийн эмч эмнэлгийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэргэжилтэн 13-ийг бэлтгэн сургаж байна. Нийт мэргэшүүлэн бэлтгэсэн тусгай мэргэжилтний тоо 21 байна. Хэрэгжилт 81,2% байна. | |
| 2.1.4.2.1 | Арга хэмжээ: Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх. | 2021-2024 | Улсын төсөв 17,6 | Сувилагч мэргэжилтний хангалтын хувь | 2019 | 83.3 | 85.6 | 2022 оны байдлаар сувилагчийн хангалт лавлагаа шатлалд 90,5%, анхан шатлалд 80,7%-тай байна. Глобал Удирдагч болон Энэрэл дээд сургуулиудтай хамтран ажиллаж нийт 6 сувилагчийг шинээр элсүүлэн суралцуулж байна. Сувилагчийн хангалтын хувь 85,6 болсон байна. | 100 |
| 2.1.4.2.2 | Дэд арга хэмжээ: "Ахмадын ордон", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-д ахмад настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх. | 2021-2024 | Улсын төсөв 2,5 | Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн тоо | 2019 | 0 | 1 | Адаацаг сумын эрүүл мэндийн төвд сэргээн засах тусламж үйлчилгээний 1 сувилагчийг мэргэшүүлэн бэлтгэлээ. Ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн хүний нөөц бэлтгэх зорилгоор сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх 1 эмчийг бэлтгэж байна. 2023 оны хүний нөөцийг мэргэшүүлэн сургах төлөвлөгөөнд 1 эмчийг сургахаар төлөвлөсөн. хБИ-ий хөгжлийн төвд ажиллах хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч 4 бэлтгэгдэж байна. | 100 |
| 2.1.4.3 | Арга хэмжээ: Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн нарийн мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг туршлага судлуулж, сургалтад хамруулах. | | Улсын төсөв 16.3 | Гадаад сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | 2019 | 44 | 54 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Монгол-Японы эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах" чанарын туршлага судлах сургалтад 41 эмч мэргэжилтэнг хамруулаа.<br>Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн 1 эмчийг мэргэшлийн дагуу 1,5 жилийн хугацаатай Япон улсад, Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн 1 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сувилагчийг БНХАУ-ын Хунань мужийн хүүхдийн эмнэлгээс зохион байгуулсан онлайн сургалтад суралцуулсан. Гадаад улс орноос зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал болон эмнэлзүйн цахим сургалтад нийт 56 эмч мэргэжилтэн хамрагдсан. | |
| 2.2 | Зорилго: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 1835-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай байсныг 2024 онд 33.9 хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| 2.2.1 | Зорилт: Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2024 онд 28105-д хүргэнэ. | 2021-2024 | УТ 1.4 | Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо | 2019 | 25193 | 26649 | Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй Эртэч монгол" аяны хүрээнд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр 10-78 насны давхардсан тоогоор нийт 42268 иргэн нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэсэн. | 100 |
| 2.2.1.1 | Арга хэмжээ: Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх | 2021-2024 | УТ 2.2 | Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн тоо | 2020 | 8125 | 10230 | Өглөөний дасгал, алхалт, дугуй, бясалгал, хийн дасгал, зөөлөн гүйлт зэрэг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр нийт 22958 иргэн тогтмол хичээллэж байна. | 100 |
| 2.2.1.1.1 | Дэд арга хэмжээ: Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх | 2021-2024 | УТ 80.0 | Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2020 | 12 | 14 | Аймгийн спортын 17 клуб, холбоодтой хамтран, улс, бүс, аймгийн аварга шалгаруулах, нэрэмжит зэрэг 80 гаруй уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийт 28500 иргэн оролцсон байна. | 100 |
| | | 2021-2024 | УТ 1.2 | Спорт хамтлагуудтай хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2020 | 26 | 32 | Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 39 байгууллагын спорт хамтлагтай хамтран спортын 36 үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 28500 иргэдийг хамруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1.1.2 | Дэд арга хэмжээ: Монгол улсын гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөрийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 2021-2023 | ОНТ 10.0 | УАШ-х тэмцээнд оролцсон багийн тоо | 2018 | 70 | 72 | Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит Өсвөрийн волейболын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын волейболын холбоотой хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнд 19 аймаг, 9 дүүрэг, 8 клубийн нийт 86 багийн 1200 гаруй тамирчид оролцсон. | 100 |
| 2.2.1.1.4 | Дэд арга хэмжээ: Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион байгуулах | 2021-2024 | УТ 3.0 | Үндэсний спортын наадамд оролцсон спортын төрлийн тоо | 2018 | 6 | 8 | Үндэсний спортын наадамд сур, шагай, уран уургач, бугуйлч, эмнэг сургагч, бөх, ширээний шагай, байт харваа, морьт харваа, зэрэг спортын 9 төрлөөр нийт 46 иргэн оролцсон.<br>Сурын харвааанд багаараа мөнгөн медаль, хувийн цуваанд мөнгөн медаль, эмнэг сургагчаар хүрэл медалийг тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100 |
| | | 2021-2023 | УТ 1.0 | Наран Хөгцтийн шагайн харвааны наадамд оролцсон багийн тоо | 2020 | 30 | 34 | Дэрэн сумын Наран хөгцтийн тойромд үндэсний уламжлалт шагайн харвааны наадмыг багийн болон хувийн цуваа харваа гэсэн 2 төрлөөр зохион байгуулж, 15 аймгийн нийт 38 багийн 266 харваачид оролцож, цэц мэргэнээ сорин өрсөлдсөн. | |
| 2.2.1.1.5 | Дэд арга хэмжээ: Сагсан бөмбөгийн 3х3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлэх | 2021-2024 | ОНТ 300.0 Хандив 66.0 | 3х3 спортын төрлөөр хичээллэгчдийн тоо | 2020 | 4000 | 4600 | Аймгийн хэмжээнд нийт 5200 иргэн 3х3 сагсан бөмбөгийн спортоор хичээллэж байна. Мөн энэхүү спортын төрлийг орон нутагт хөгжүүлэх зорилгоор Хаан банкны 66 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар багт, аймгийн төвийн Айраг, Мандал, Боржигон багуудад орон нутгийн хөгжлийн сангийн нийт 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3х3 сагсан бөмбөгийн талбайг барьж ашиглалтад оруулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021-2024 | - | 3х3 спортын багш, дасгалжуулагч, шүүгчээр бэлтгэгдсэн хүний тоо | 2020 | 0 | 22 | Сургуулийн биеийн тамирын багш болон клубийн дасгалжуулагч зэрэг нийт 22 багш дасгалжуулагчид сургалт зохион байгуулж, 3х3 спортын шүүгчээр бэлтгэсэн. | |
| 2.2.1.2 | Арга хэмжээ: Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулах | 2021 | УТ 50.0 | Спортын талбайн гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлийн хувь | 2020 | 0 | 75 | Цэнгэлдэх хүрээлэнгийн ажлын гүйцэтгэгчээр "Зуут Констракшин" ХХК ажиллаж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн. Тус хүрээлэнгийн спортын талбайд үндсэний сурын 10 зурхайтай шинэ талбай, шагайн харвааны 8 багийн тоглолтын талбай зэргийг ашиглалтад оруулаа. | 100 |
| **2.3.** | **Зорилго:** Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| **2.3.1** | **Зорилт:** Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2024 онд 76 хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | СӨБ-ын хамран сургалтын хувь | 2020 | 72.5 | 74 | 2022-2023 оны хичээлийн жилийн 2-4 настай хүүхдийн хамран сургалт 74,9 хувь байна. 5 настай хүүхдийн хамран сургалтын хувь 84,6 байгаа нь өмнөх оныхоос 0,4 хувь өссөн үзүүлэлттэй байна. Энэ хичээлийн жилд хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор хувилбарт сургалтыг 6 сумын 184 хүүхдийг хамруулан хамран сургалтын хувийг нэмэгдүүлсэн байна. | 100 |
| 2.3.1.2 | Арга хэмжээ: Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургана. | 2021-2024 | - | Хөгжим тоглож сурсан бүлгийн багшийн эзлэх хувь | 2020 | 0 | 40 | 2021-2022 оны хичээлийн жилд 22 цэцэрлэгийн бүлгийн багш нар хөгжим тоглож сурах сургалтыг цэцэрлэг тус бүр дээрээ зохион байгуулан ажиллаж байна. Нийт 97 бүлгийн багш буюу 97,8 хувь нь хөгжим тоглох сургалтад хамрагдаж байна. 22 цэцэрлэгийн бүлгийн багш нарт 2-р шатны сургалтыг зохион байгуулж байна. Нийт 15 багш хамрагдсан. Энэ арга хэмжээний үр | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дүнд цэцэрлэгт дуу хөгжмийн багш байхгүй тохиолдолд дуу хөгжмийн хичээлийг бүлгийн багш орох боломжоор хангагдаж байна. Нийт 99 бүлгийн багшаас 98 бүлгийн багш 1-р шатны сургалтад бүрэн хамрагдаж 2-3 дууны ая тоглож сурсан. | |
| 2.3.1.3 | Арга хэмжээ: СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021-2024 | Хандив туслам ж 26.0 | Хөгжим болон биеийн тамирын хичээлийн кабинетын тоо | 2020 | 2 | 12 | Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг, Өлзийт, Өндөршил, Цагаандэлгэр сумын хүүхдийн цэцэрлэг улсын төсвийн зохицуулалт болон иргэдийн хандив тусламжаар 19,000,000 төгрөг, улсын төсвийн зардлаас 705000 төгрөгөөр хөгжмийн болон биеийн тамирын сургалтын хэрэглэгдэхүүн шинээр авч хүүхэд хөгжих орчин бүрдүүлсэн. Хөгжмийн хичээлийн кабинетын тоо 18, биеийн тамирын хичээлийн кабинетын тоо 2 нийт 20 кабинет тоног төхөөрөмжөөр хангагдан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж байна. | 100 |
| 2.3.2 | Зорилт: ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь байсныг 2024 онд 96.5 хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | Бага, суурь боловсролын хамран сургалтын хувь | 2020 | 91.6 | 94.5 | 2021 оны жилийн эцсийн хүн амын тоотой харьцуулсан судалгаагаар Бага боловсролын хамран сургалт 94,3, суурь боловсролын хамран сургалт 96,1 байна. Аймгийн хэмжээний бага, суурь боловсролын хамран сургалтын дундаж хувь 95,1 хувь байна. emongolia системээс хаяг харьяалал татдаг болсонтой холбоотой хамран сургалтын хувь өмнөх жилүүдээс 3,7 хувь өссөн байна. | 100 |
| 2.3.2.1 | Арга хэмжээ: Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, | 2021-2024 | Улсын төсөв 2946,3 | Тухайн жилийн гүйцэтгэлийн хувь | 2020 | 0 | 100 | Тухайн жил Сайхан-Овоо сумын сургуулийн барилгыг 2022 онд барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих | | | | | | | хэрэгжүүлж, улсын комисс хүлээж авсан. Бусад сумдын сургуулиудыг дараа онуудад үе шаттай барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. | |
| | | | | Хөрөнгө шийдвэрлэсэн барилгын тоо | 2020 | 0 | 1 | Сайхан-Овоо сумын сургуулийн барилгын нийт хөрөнгө 5154,3 төгрөгөөс 2022 онд 2946,3 төгрөг төсөвт суулгаж шийдвэрлэсэн. | |
| 2.3.2.3 | Арга хэмжээ: Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад оронд мэргэжил дээшлүүлэх | 2022-2024 | - | Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо | 2020 | 0 | 4 | Сайнцагаан сумын ЭДЦС-ийн 2 багш Английн International House of London байгууллагын 2 сарын мэргэжил дээшлүүлэх цахим сургалт, Цэгцбилиг сургуулийн орос хэлний багш Санктпетер бургин их сургуулийн ТРКИ сургалтад, аймгийн БШУГ-ын 1 мэргэжилтэн Солонгос улсад цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах сургалтад тус тус хамрагдаж гэрчилгээ авч, ажлын байрнаасаа гадаад орны туршлагаас суралцсан ажил болов. Гадаад хэлний 12 багшийг зуны амралтаар нь мэргэжил дээшлүүлэх вакум сургалтад хамруулсан. | 100 |
| 2.3.2.3 .1 | Дэд арга хэмжээ: Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх | 2021-2024 | ОНТ 18.0 | Гэрээ байгуулсан оюутны тоо | 2020 | 0 | 4 | Аймгийн боловсролын салбарын 41 байгууллагаас 2022-2024 онд дутагдалтай байгаа багш нарын судалгааг авч, нэгтгэн ЕБС-иудад 2022 онд 50, 2023 онд-17, 2024 онд 17 мэргэжлийн багшийн дутагдал үүсэх судалгаа гараад байна. Иймд орон нутагтаа хүний нөөцийн бодлогын хүрээнд МУБИС, МУИС-д суралцаж байгаа 1-4-р дамжааны нутгийн оюутнуудын судалгааг авч, МУБИС-ийн Оюутны албатай хамтран аймгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | харьяат 3-р дамжааны 9 оюутантай цахим уулзалт хийж, аймгийн 8 сургууль, цэцэрлэгийн удирдлагууд оролцон ажлын байрны саналыг хүргүүлэн ажиллаж, **2021-2022 оны хичээлийн жилд 3 оюутантай, 2022-2023 оны хичээлийн жилд 6 оюутантай** гэрээ байгуулсан нь хүний нөөцийг бүрдүүлсэн арга хэмжээ болсон. Гэрээгээр төгсөж ирсэн оюутнууд Мандал, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумын сургуулиудад багшилж байна. | |
| 2.3.2.4 | Арга хэмжээ: Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулах | 2021-2024 | - | 10 судлагдахууны аймгийн дундаж оноо | 2020 | 498.4 | 502 | БШУГ-ын Даргын баталсан хуваарийн дагуу 2 удаагийн сорилыг зохион байгуулж, 10 судлагдахууны сорилын даалгаврын гүйцэтгэлийг цахимаар танилцуулсан. Аймгийн Засаг даргын дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа Elab цахим сайтад БДБ олгож байгаа 8 сургуулийн 189 сурагчийн бүртгэлийг дахин сэргээн, тухайн сурагчдыг хариуцан ажиллах мэргэжлийн багш нарыг сайтад холбон ажиллуулсан. 2022 оны ЭЕШ-ын дундаж 509,59 оноотой шалгагдсан нь зорилтод түвшинд хүрсэн байна. | 100 |
| 2.3.2.4.1 | Дэд арга хэмжээ: Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь зөвлөх багийн үйлчилгээнд хамруулах | 2021-2024 | Улсын төсөв 1.0 | Бага боловсролын багш нарын хамрагдалтын хувь | 2020 | 50 | 80 | БШУГ-ын Даргын баталсан удирдамжийн дагуу 3 сарын туршид аймгийн ЕБ-ын 19 сургуульд Зөвлөн туслах ажлыг зохион байгуулав. Зөвлөн туслах багийн үйлчилгээнд аймгийн бага боловсролын 159 багш буюу 100 хувь хамрагдсан. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021-2024 | Улсын төсөв 1.0 | Суурь боловсролын багш нарын хамрагдалтын хувь | 2020 | 50 | 80 | Зөвлөн туслах багийн үйлчилгээнд аймгийн суурь, бүрэн дунд боловсролын 363 багш буюу 100 хувь хамрагдсан. Зөвлөн туслах ажлын хүрээнд багшийн хичээлд суун зөвлөн тусалж, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт, улсын болон анги дэвших шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажилтай танилцсан нь тэдний төлөвлөлт, арга зүйг дээшлүүлсэн ажил болов. | |
| 2.3.2.5 | <u>Арга хэмжээ</u>: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021-2024 | Улсын төсөв 1.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2020 | 0 | 65 | Чадварлаг багш хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сургууль, цэцэрлэг бүр батлан, 2022 оны 11 сарын 1-ний байдлаар цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн дундаж 82, сургуулийнх 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 12 сургууль, цэцэрлэгийн 143 багш арга туршлагаа түгээн дэлгэрүүлж, 17 судлагдахууны мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулагдан ажилласан багаараа багш нар хөгжиж, шинэ арга зүйг бий болгосон ажил болсон байна. | 100 |
| 2.3.2.5.1 | <u>Дэд арга хэмжээ</u>: СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоодод туршлага судлуулах | 2021-2024 | Улсын төсөв 6.3 | Тухайн жилд туршлага судалсан багшийн тоо | 2020 | 27 | 60 | Аймгийн ЕБ-ын 19 сургууль давхардсан тоогоор 30 удаагийн 62.5 хоногийн дотоодын туршлага судлах арга хэмжээг өөрийн аймгийн болон бусад аймаг, нийслэлийн сургууль, олон улсын хөтөлбөртэй сургуулиудад зохион байгуулж, 455 удирдах болон мэргэжлийн багш нарыг хамруулан сургалтын чанарыг ахиулахад шинэ арга, технологийг эрэлхийлсэн, туршсан ажил арга хэмжээ болж, 273 багш арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байна. 22 цэцэрлэгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрхлэгч, БШУГ-ын СӨБ-ын мэргэжилтнээр ахлуулсан баг нийслэлийн Улсын тэргүүний 146-р цэцэрлэг, 3-р цэцэрлэгийн хамт олон Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын цэцэрлэгийн сургалт үйл ажиллагаа, сургалтын орчинтой танилцаж туршлага судалсан. 22 цэцэрлэгийн 68 багш, 22 эрхлэгч, 13 арга зүйч нийт 103 багш, удирдах ажилтан туршлага судалсан байна. | |
| 2.3.2.5.2 | Дэд арга хэмжээ: ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021-2024 | Улсын төсөв 800.0 Хандив 10.0 | Хөгжмийн хичээлийн кабинетын тоо | 2020 | 2 | 11 | Их соёл-Эх үндэс" хөтөлбөрийн хүрээнд хөгжмийн кабинетын 800 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 19 сургуульд нийлүүлж, хөгжмийн зэмсгээр хангагдаад байна. Кабинетын тоо 14, хэрэгжилт 100 хувьд хүрлээ. | 90 |
| | | 2021-2024 | | Биеийн тамирын хичээлийн кабинетын тоо | 2020 | 2 | 11 | Биеийн тамирын сургалтын орчныг сайжруулах, сурагчдын танин мэдэхүйд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Олимп танхим"-ыг шинээр 6 сургуульд байгуулан ашиглалтад оруулсан. Нийт 8 кабинеттай боллоо. | |
| 2.3.2.6 | Арга хэмжээ: Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах | 2021-2024 | - | Сургалтад хамрагдсан суралцагч, иргэд, эцэг эхийн хувь | 2019 | 32 | 36 | Насан туршийн боловсролын төв болон сумдын Нэгжийн багш нар Санхүүгийн боловсролын болон АМЧБОлгох 14 удаагийн сургалтад 1202 хүүхдийг хамруулан төсвийн зарцуулалт, ажил мэргэжлийн чиглэлээр мэдлэг мэдээлэлтэй болгосон байна. Насан туршийн боловсролын 11 чиглэлийн сургалт болон нөлөөллийн үйл ажиллагаанд нийт иргэдийн 70 хувь нь хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2.7 | <u>Арга хэмжээ</u>: Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах | 2021-2024 | Улсын төсөв 35.0<br><br>ОНТ 30.0 | Танхимын тоо | 2020 | 0 | 7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхимыг Мандал, Говийн-Ирээдүй, Хулд, Өндөршил, Сайхан-Овоо, Дэрэн сумын сургуулийн байр болон дотуур байранд байгуулж, 6 танхимд үйл ажиллагаагаа явуулж байна. | 85.7 |
| 2.3.2.8 | <u>Арга хэмжээ</u>: Сургууль бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах | 2021-2024 | Хандив туслам ж 23.9 | Байгуулсан кабинетын тоо | 2020 | 3 | 9 | Аймгийн ерөнхий боловсролын 9 сургууль хими, биологи, физик, багын байгалийн ухааны 11 кабинетыг шинээр байгуулж, байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг ахиулах материаллаг баазыг бүрдүүлэхэд 2022 онд 23,9 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна. | 100 |
| 2.3.2.9 | <u>Арга хэмжээ</u>: Сургууль, дотуур байрыг 100% шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох | 2021-2024 | Эрднэт үйлдвэр ийн санхүүж илт 666.6 | Дотор нойлтой сургуулийн тоо | 2020 | 12 | 15 | Ерөнхий боловсролын 19 сургуулиас Говь-Угтаал, Дэлгэрцогт сумын сургуулиас бусад 17 сургууль буюу 90 хувь нь нойлтой болсон байна. Гүйцэтгэл 100 хувь | 92,6 |
| | | 2021-2024 | Эрдэнэ т үйлдвэр ийн санхүүж илт 666.6 | Дотор нойлтой дотуур байрны тоо | 2020 | 10 | 14 | Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумын сургуулиас бусад 13 дотуур байр дотор нойлтой. Говь-Угтаал, Адаацаг суманд шинэ дотуур байр барихаар ирэх жилийн хөрөнгө оруулалтад төлөвлөсөн. Дэрэн сумын дотуур байр Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 3-р шатанд хийгдэхээр төлөвлөлтөд орсон. Гүйцэтгэл 92 хувь | |
| | | 2021-2024 | Эрдэнэ т үйлдвэр ийн санхүүж | Усанд орох нөхцөл бүрдсэн дотуур байрны тоо | 2020 | 11 | 15 | Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумын сургуулиас бусад 13 дотуур байр усанд орох нөхцөл бүрдсэн. Говь-Угтаал, Адаацаг суманд шинэ дотуур байр барихаар ирэх жилийн хөрөнгө | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | илт 666.6 | | | | | оруулалтад төлөвлөсөн. Дэрэн сумын дотуур байр Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар 3-р шатанд хийгдэхээр төлөвлөлтөд орсон. Хэрэгжилт 86 хувь | |
| 2.3.2.10 | Арга хэмжээ: Цэцэрлэг, сургууль, дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах | 2021-2024 | Улсын төсөв 200.0 | камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь | 2020 | 50 | 70 | Салбарын 58 барилга байгууламжаас 2022 онд 18 сургууль, 17 дотуур байр, 20 цэцэрлэгийг 200 сая төгрөгөөр бүрэн камержуулсан байна. Гүйцэтгэл 94,8 хувь | 100 |
| | | 2021-2024 | | хураан авсан ургацын хэмжээ(тн) | 2020 | 2.8 | 5.8 | 16,4 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 10,6 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| 3.3.1.9 | Арга хэмжээ: Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах | 2021-2024 | - | Бойжуулсан бизнес эрхлэгчийн тоо | 2020 | 36 | 60 | 20 бизнес эрхлэгчийг зөвлөгөө мэдээллээр хангаж, цаашдын зээл авах үйл ажиллагаа өргөжүүлэхэд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэж тодорхойлолт олгосноор 60 иргэн Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болсон байна. Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулах, үйлдвэрлэлийг өргөтгөх зорилгоор Төв аймгийн Баянчандмань сумын сүү, ногоо, тахиа, салфетканы үйлдвэрүүд болон Улаанбаатар хотын "Цэвэр хөрсний шим" дундын хоршооны мөн Хэнтий аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сумдад зохион байгуулагдсан аялалд 10 хүнийг хамрууллаа. | 100 |
| 3.3.1.10 | Арга хэмжээ: Өлзийт суманд ингэний фермерийн аж ахуйг байгуулж, сүүг үйлдвэр цехэд нийлүүлэх | 2021-2024 | - | Саалинд хамрагдах ингэний тоо | 2020 | 0 | 100 | Өлзийт сумын 4 малчин өрхөд 1 ээлжийн 50 ингийг түрээсийн гэрээгээр маллуулж байна. Хэрэгжилт 50%. | 50 |
| | | 2021-2024 | - | Нийлүүлсэн сүүний хэмжээ (тн) | 2020 | 0 | 11 | 5,5 тонн сүүг зах зээл нийлүүлээд байна. Хэрэгжилт 50%. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2. | Зорилт: Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд шинээр нэвтрүүлж малын хаврын амьдын жинг 3-5 хувиар нэмэгдүүлнэ | 2021-2024 | Хандив 1,5<br>ОНТ 2,0 | шинээр хамрагдсан малын тоо | 2019 | 0 | 500 | Энэ онд 350 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Битүү хөнгөлгөөний аргыг 500 хурга, 150 ишиг, 30 бяруунд туршиж нийт 1030 малд биотехнологийн ололтыг нэвтрүүллээ. 8 сартай хурганы амьдын жинг 7-12кг, махны гарцыг 3-5кг нэмэгдүүлсэн. | 100 |
| | | 2021-2024 | - | Малын амьдын жингийн өсөлт хувь | 2019 | 1 | 2 | Биотехнологийн ололтыг нэвтрүүлж зохиомол хээлтүүлгээр гарсан төлийн төрөх үеийн амьдын жин 4,3 кг байсан нь дур зоргын хээлтүүлгээр гарсан төлийн төрөх үеийн амьдын жингээс 5-8%-иар өсөлт нэмэгдсэн. | |
| 3.3.2.1 | Арга хэмжээ: Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх | 2021-2024 | хувийн хөрөнгө 1,5<br>ОНТ 2,0 | Хээлтүүлсэн малын тоо | 2020 | 500 | 1300 | Сайнцагаан омгийн хээлтэгчид Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч тус тус хээлтүүлэг хийсэн ба энэ онд 350 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Нийт 1150 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна. | 81,3 |
| 3.3.2.2 | Арга хэмжээ: Олдохын хүрэн бор тэмээний тоог өсгөх замаар сумдад сайжруулагчаар ашиглах | 2021-2024 | Хандив 30,0 | Сайжрагдсан тэмээний тоо | 2019 | 570 | 650 | Өмнөговь, Дорноговь аймаг болон өөрийн аймгийн Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай зэрэг сумдад 15 өсвөр буурыг захиалгын дагуу нийлүүллээ. Ингэснээр нийт 945 тэмээнд сайжруулагчаар ашиглаж байна. | 100 |
| 3.3.2.3 | Арга хэмжээ: Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд омгоор баталгаажсан Өндөршил адуу, Сайнцагаан хонины үрийг хадгалах | 2022-2023 | - | Тухайн жилд генийн санд хадгалсан үрийн тун | 2020 | 0 | 500 | Малын удмын сангийн үндэсний төвийн гений санд Сайнцагаан омгийн 3 хуц, монгол үүлдрийн 3 хуцанаас 1250 тун үр авч хадгалуулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2.4 | Арга хэмжээ: Аймгийн хэмжээнд үхэр сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021-2024 | - | ашиг шим нь нэмэгдсэн үхэр сүргийн тоо | 2020 | 0 | 140 | Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 өсвөр хээлтүүлэгчийг Баянжаргалан сумын 150 үнээнд сайжруулагчаар ашигласан. Хээл авалт 100 %-тай. Сэлэнгэ үүлдрийн үхрийн гүн хөлдөөсөн үрээр Луус суманд зохиомол хээлтүүлгийг 15 үхэрт хийсэн. | 100 |
| 3.3.2.6 | Арга хэмжээ: Жилд 20-оос доошгүй стандартын шаардлага хангасан бух бойжуулж үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах | 2021-2024 | хувийн хөрнгө 40,5 | Бойжуулсан бухны тоо | 2019 | 974 | 1004 | Аймгийн хэмжээнд орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлаж шинээр 31 өсвөр бухыг тавьснаар 1005 стандартын шаардлага хангасан бухыг бойжуулж үхэр сүргийг сайжруулж байна. | 100 |
| 3.3.2.7 | Арга хэмжээ: Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг эмэгжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах | 2021-2024 | Хувийн хөрөнгө 3,5 | Эмэгжүүлж бүртгэлжүүлсэн малын тоо мян,тол | 2019 | 90 | 96 | Энэ онд Мал эмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд сумдад стандартын шаардлага хангасан 6200 толгой бог малын хээлтэгч, хээлтүүлэгч, хэрэгцээний сүргийг эмэгжүүлэн бүртгэлжүүллээ. Аймгийн хэмжээнд нийт 96,2 мян.толгой малыг эмэгжүүлж бүртгэлжүүлээд байна. | 100 |
| 3.3.3. | Зорилт: Нийт 7.4 сая га бэлчээрийн талбайн 70 хувьд бэлчээрийн даац 3 дахин илүү хэтрэлттэй байгаагийн 26 га талбайг 2024 гэхэд нөхөн сэргээнэ. | 2021-2024 | 10.0 ОНТ | Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ (га) | 2020 | 0 | 6 | Өвөлжөө, хаваржааны дэргэд 43,3 га бэлчээр хашиж, 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 29,6 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэн нийт 29,6 мянган га бэлчээрийн талбайг нөхөн сэргээгээд байна. | 100 |
| 3.3.3.1 | Арга хэмжээ: Олон дахин хэтэрсэн болон талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээх | 2021-2024 | - | Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ (га) | 2020 | 0 | 11 | Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Өндөршил, Сайнцагаан, Сайхан-Овоо,Хулд, Эрдэнэдалай сумдын 17 малчин өрх 12,0 га талбайд тэжээлийн ургамал тариалсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.2 | Арга хэмжээ: Дэрэн суман дахь тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж аймгийн тэжээлийн нөөцийн 60-аас доошгүй хувийг үйлдвэрлэх | 2021-2024 | | Хүчин чадлын ашиглалтын хувь | 2020 | 0 | 20 | Дэрэн сумын тэжээлийн үйлдвэр тоног төхөөрөмж, ажиллах хүч, санхүүгийн эх үүсвэргүй улмаас тэжээл үйлдвэрлэх боломжгүй байсан. | 0 |
| 3.3.3.3 | Арга хэмжээ: Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 2021-2024 | - | Хамгаалсан талбайн хэмжээ (мян/га) | 2019 | 267 | 278 | Өвөлжөө, хаваржааны дэргэд Говь-Угтаал, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 21 малчин өрх 43,3 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалсан. Нийт 310.3 га талбайг хамгаалаад байна. | 100 |
| 3.3.3.4 | Арга хэмжээ: Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах | 2021-2024 | 10.0 ОНТ | Тэмцсэн талбайн хэмжээ (мян/га) | 2020 | 100 | 160 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 185 дугаар тогтоол "Бэлчээр хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Үлийн цагаан оготнотой тэмцэх" А/166 захирамжаар Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар 29,5 мянган га талбайд тэмцсэн. нийт тэмцсэн талбайн хэмжээ 159,5 мян.га талбайд бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцсэн байна. | 99.1 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3.5 | Арга хэмжээ: Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулах | 2021-2024 | төсөл хөтөлбөр112,0<br>ОНТ 112,0 | Тухайн жилд шинээр гаргах худгийн тоо | 2019 | 3382 | 3 | Төсөл хөтөлбөр, Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 810,6 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдуудад инженерийн хийцтэй 25 худаг, Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдуудад 27 цооног, Баянжаргалан, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдуудад энгийн уурхайн 32 худгийг сэргээн засварлаж бэлчээрийн 110,0 мянган га талбайг усжуулж бэлчээр усжуулалтыг 1,5 хувиар нэмэгдүүлсэн. Шинээр 8 худаг гаргасан. | 100 |
| 3.3.4 | Зорилт: 2020 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 650 мянган толгой мал хамруулсныг 2024 онд 200 мянган толгой мал болгож вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | УТ 221,1 | Хамруулсан малын тоо (мян/төл) | 2021 | 430,0<br>15000 | 350,0<br>17088 | Орон нутгаас хариуцдаг дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 12,4 мянга үхэр, ДХХ-Энтеробактериоз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 327,9 мянган бог мал, бүгд 350,3 мянган мал хамруулав. | 100 |
| 3.3.4.1 | Арга хэмжээ: Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгох | 2021-2024 | - | Гэрчилгээний тоо | 2021 | 15000 | 17000 | Хүнсний зориулалтаар зах зээлд гарч буй мал, амьтан, мах, түүхий эд бүтээгдэхүүнд эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын баталгаа гаргаж, хүнсний болон худалдааны зориулалтаар 17000 мал эмнэлгийн гэрчилгээ олгосон. Малын гоц халдварт өвчин тархаж ихэнх аймгууд, малын шилжилт хөдөлгөөнийг хориглосон тул отор нүүдлийн малд мал эмнэлгийн гэрчилгээ олгоогүй. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.4.2 | **Арга хэмжээ:** Сум бүрийг вакцин хадгалах хөргүүр, багуудыг мал угаалгын ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашаа барих | 2022-2024 | ОНТ 54,0 | Хөргүүртэй болсон сумын тоо | 2021 | 0 | 5 | Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Өндөршил, Луус, Эрдэнэдалай 6 сум Тэнүүн хишиг ХХК -аас вакцин хадгалах хөргүүр худалдан авч ашиглаж байна. | 100 |
| | | 2021-2024 | ОНТ 100,0 | шинээр нэмэгдсэн мал угаалгын ванны тоо | 2021 | 15 | 25 | Дэлгэрцогт суманд Орон нутгийн хөгжлийн сангаар 1 ванн 27,0 сая төгрөгөөр барьж, 10,0 сая төгрөгөөр 1 ванн сэргээн засварлаж ашиглалтад оруулсан. Гурвансайхан суманд 2, Өлзийт суманд 1 ванныг малчдын бүлгийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан. Мал угаалгын 5 ванн ашиглалтад оруулсан. Ингэснээр 25 мал угаалгын ванн ашиглалтад ороод байна. | |
| | | 2021-2024 | ОНТ 25,0 | мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашааны тоо | 2020 | 0 | 8 | Дэлхийн зөн олон улсын байгууллагаас Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд бод малд үйлчилгээ үзүүлэх хашаа, зогсоол, бог малд үйлчилгээ үзүүлэх хашаа, зогсоол, Өндөршил, Говь-Угтаал, Дэрэн сум мал эмнэлгийн үйлчилгээний нэгждээ орон нутгийн хөгжлийн сангаас үйлчилгээ үзүүлэх хашаа авч өгсөнөөр нийт 13 хашаагаар үйлчилгээ үзүүлж байна. | |
| 3.4.1 | **Зорилт:** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад, дотоод жуулчдын тоог 26000-д хүргэнэ. | 2021-2024 | УТ, ОНТ, Хувийн хэвшил 1686.0 | Дундговь аймагт ирсэн гадаад, дотоодын жуулчдын тоо | 2019 | 19540 | 22000 | Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаадын 9657 жуулчин, дотоодын 30257 жуулчин ирсэн байна. Нийт 39914 аялагч, жуулчид ирсэн. | 100 |
| 3.4.1.1 | **Арга хэмжээ:** Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой | 2021-2024 | ОНТ 36.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2019 | 4 | 8 | Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газар 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр "Тэмээний баяр" зохион | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эвент арга хэмжээг нэмэгдүүлэх. | | | | | | | байгуулсан. Тус эвент арга хэмжээнд 7 сумын 74 тэмээчин оролцож, 230 хүн үзэж сонирхсон.<br>Цагаан суварга дахь "Говь караванcерай" жуулчны баазтай хамтран "Сэтгэшгүй оддын чуулган" эвент арга хэмжээг зохион байгуулж 220 аялагч, жуулчид үзэж сонирхсон.<br>"Дуу хуур, өв соёлын өлгий нутаг" Дундговь аймгийн 80 жилийн ойн баяр наадмыг гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор урлаг, соёлын фестиваль болгон тэмдэглэсэн. Тус арга хэмжээний нээлт, урлагийн тоглолтыг 15000 хүн үзэж сонирхсон.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны 09 сарын 05-ны өдрийн А/350 захирамжаар "Адууны өв соёлын баяр" эвент арга хэмжээг Адаацаг сумын "Сүм хөх бүрд" байгалийн дурсгалт газарт 09 дүгээр сарын 10, 11-ны өдөр зохион байгуулсан. Тус эвент арга хэмжээнд 15 сумын 42 адуучин оролцож, гадаад, дотоодын 1200 хүн үзэж сонирхсон.<br>2022 онд 4 эвент арга, 2021 онд 1 арга хэмжээ зохион байгуулж, нийт 9 болж, 16650 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. | |
| 3.4.1.2 | <u>Арга хэмжээ:</u> Жуулчдын голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий Дэл уул зэрэг газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах | 2022-2024 | УТ 197.2 | Тухайн жилд байгуулах отоглох цэгийн тоо | 2020 | 1 | 1 | Тус аймгийн Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт "Отоглох цэг" байгуулсан. Отоглох цэгт 1,2 га талбайн хамгаалалтын хашаа, Машины зогсоол 40, Майхан барих талбай 31, Ариун цэврийн байгууламж 24 мкв байр, септик танктай, Шингээлгийн талбай 36 мкв, ОО 5, Угаалтуур 2, Ус нөөцлөх сав 2, Явган | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зам 120 м, Гэрэлтүүлэг 8, Сүүдрэвч 2, Ширээ, сандал 4, Гал түлэх цэг 2, Шорлогны зуух 2, Угтах хаалга, Мэдээллийн самбар 2, Тэмдэг, тэмдэглэгээ 13, Тэмээн зэл 1 ширхгийг хийсэн. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны Дугаар 21/2022 үүрэг даалгаврын биелэлт, актаар хүлээж авсан. | |
| 3.4.1.3 | Арга хэмжээ: Сүм хөх бүрд зэрэг аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлнэ. | 2022-2024 | УТ 999.2 | ААНэгжид үзүүлсэн дэмжлэгийн тоо | 2020 | 0 | 1 | Сүм хөх бүрдэд 2 цомцог гэр, шилэн нүүр бүхий 150 хүний багтаамжтай асар, гэрэлтүүлэг, зөөврийн шилэн тайз зэрэг хөрөнгө оруулалтыг БОАЖЯамнаас "Ижий говь" төслийн хүрэнд нийлүүлснээр 8 ор хоног нэмэгдэж хүчин чадал, үйлчилгээний чанарын стандарт сайжирсан. Тус төслийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 сарын 17-ны өдрийн дугаар 03 актаар хүлээж авсан. | 100 |
| 3.4.1.4 | Арга хэмжээ: Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи гэх зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчилна. | 2021-2024 | БХНСА Х32.0<br><br>Хувийн хэвшил 2.1 | Гадаад жуулчдыг хүлээн авах байгуулсан гэрээний тоо | 2020 | 100 | 200 | Монголын Аялал Жуулчлалын Холбоо" ТББ-аас "Аялал жуулчлал – Бизнес хэлцэл" үйл ажиллагаанд 200 тур оператор компанийн төлөөлөл оролцсон бөгөөд Дундговь аймгаас "Цагаан суварга", "Говь каравансерай", "Эрдэнэ-Ухаа", "Бага газрын чулуу", "Онгийн нууц" гэсэн 5 жуулчны бааз оролцож тур оператор компаниудтай 2022 онд жуулчин авах гэрээ 223 байгуулсан.<br>ITM 2022 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Говийн шуранхай АЖхолбоо, Цагаан суварга, Эрдэнэ- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ухаа, Баянбулаг, Онги-Энержи, Бага газрын чулуу, Говь хулан, Онгийн нууц жуулчны баазууд, Сүм хөх бүрд, Ачлал-Оргил амралтын газар гэсэн 9 аж ахуйн нэгж байгууллага нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай 2023 онд жуулчин хүлээн авах 257 гэрээ байгуулж, 2100 тараах материал тарааж ажиллалаа | |
| 3.4.1.5 | Арга хэмжээ: Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах | 2021-2024 | ОНТ, хувийн хэвшил 3.5 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2019 | 0 | 3 | Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газартай хамтран малчин иргэдийг аялал жуулчлалд холбох, морин аялал зохион байгуулахад аргазүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж Хустайн байгалийн цогцолборт газрын "Баян сонгинот" нөхөрлөл болон Тэрэлжид морин аяллын газарт туршлага солилцох аяллыг хийсэн. Мөн Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс тус сумын малчин иргэдэд зориулсан морин аялал хийх сургалтад 14 малчин хамрагдсан. Жуулчны баазуудын хөтөлбөрт үйл ажиллагаа Айраг найргийн үдэш, Адууны өв соёлын баяр, Шөнийн музей зэрэг хөтөлбөрт өв соёлын арга хэмжээг зохион байгуулж 1500 хүн үзэж сонирхсон. | 100 |
| 3.4.1.6 | Арга хэмжээ: Жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төвийг байгуулах | | ОНТ 56.5 | Мэдээллийн төвөөр үйлчлүүлэгчдийн тоо | - | - | 220 | Аялал жуулчлалын мэдээллийн төв нийлүүлэх тендерт "Сайнцагаан өргөө" ХХК шалгарч ДУГАОНӨГ/202202067 гэрээ байгуулж, тэрэг хэлбэртэй модон шалтай Цомцог гэрийг Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрийн баруун талд байрлуулсан. Мэдээллийн төвийг 2022 оны 08 дугаар сарын 12-ний өдрийн 01 дугаар актаар комисс хүлээж авсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Тус мэдээллийн төвд аялал жуулчлалын чиглэлийн баяр ёслол, хурал, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж нийт 230 хүнд үйлчиллээ. Айхотел ХХК-тай гэрээ байгуулж "Дундговь" аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформыг хийлгэсэн. | |
| 3.4.1.7 | Арга хэмжээ: Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг салбарын ажилтнууд болон иргэдийг хамруулж боловсон хүчнийг бэлтгэх | 2021-2024 | ОНТ 30.0 | Тухайн жилд сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 2020 | 120 | 140 | Аймгийн Засаг даргын 2022 оны 02 сарын 16-ны өдрийн А/51 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж "Дундговьд төвлөрцгөөе" аялал жуулчлалын анхдугаар форумыг 03 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус форумд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 175 хүн оролцож илтгэл, мэдээлэл, сургалтад хамрагдсан. | 100 |
| 3.4.1.8 | Арга хэмжээ: Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэх | 2021-2024 | ОНТ 0.5 | Үнэлгээний дундаж хувь | 2020 | 80 | 85 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 76 дугаар тоотоор аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгжид үйлчилгээний стандарт, тохирлын гэрчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сайхан-Овоо сумын "Цогтын шар мөрөн"ХХК-ний тохирлын үнэлгээ 85%-тай үнэлэгдэж тохирлын гэрчилгээгээ авсан. Өлзийт сумын "Говь каравансерай" жуулчны бааз тохирлын үнэлгээ нь 95%-тай үнэлэгдсэн ба үнэлгээний дундаж 90 хувьтай байна. | 100 |
| 3.4.1.9 | Арга хэмжээ: Аялал жуулчлалын бүс нутгуудад менежментийг сайжруулах | 2022 | УТ 269.0 | Менежмент хэрэгжүүлсэн газрын тоо | 2020 | 0 | 1 | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 сарын 13-ны өдрийн 24 дугаар тогтоолоор "Дэл | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | уулын соёлын өвийн менежмент"-ийн төлөвлөгөө батлагдсан. Тус менежментийн төлөвлөгөөний хүрээнд Цагаан суваргат "Отоглох цэг" мэдээллийн самбар, тохижилтын ажлыг хэрэгжүүлсэн. Мөн Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Нарт дизайн" ХХК шалгарч ажлын даалгаврын дагуу төлөвлөгөөний эхний үе шатыг танилцуулсан. | |
| 3.4.1.10 | Арга хэмжээ: Өлзийт, Гурвансайхан сумдад аялал жуулчлалын цогцолбор байгуулах | 2021-2022 | УТ 269.0<br>Хувийн хэвшил 90.0 | Цогцолборын тоо | 2020 | 0 | 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагаан суваргын аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөг "Нарт дизайн" ХХК хийж гүйцэтгэж байна. Цогцолбор байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн Цагаан суваргат хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар "Говь хулан" жуулчны бааз шинээр байгуулагдсан. | 30 |
| 3.5.1 | Зорилт: Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дэд бүтэц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр хангана. | 2021-2024 | 361.0 ТӨХК | Тухайн жилд ашиглалтад орсон ажлын тоо | 2020 | 2 | 3 | 2022 онд эрчим хүчний салбарын хүрээний 2 төсөл арга хэмжээний ажил ашиглалтад орохоос Хулд сумын 0,4кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний ажил ашиглалтад орсон. | 50 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1.1 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчилж, ашиглалтад оруулах | 2021-2022 | 2,680 төсөл | Ажлын гүйцэтгэлийн хувь | 2020 | 0 | 100 | Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100% шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлыг "Проект ватт" ХХК-тай 4,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. 4800ш ухаалаг тоолуур солихоос 1000ш ухаалаг тоолуур суурилуулсан. 52км 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаас 50км угсарсан. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай. БНХАУ-ын хэл хаагдсанаас материал байхгүйгээс энэ жилийн ажил зогссон. | 80 |
| 3.5.1.2 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн төвийн дулааны станцын ажлыг эхлүүлэх | 2021-2024 | - | Ажлын гүйцэтгэл хувь | 2020 | 0 | 25 | Эрчим хүчний яам "10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл" төсөл хэрэгжүүлэх нэгж дээр аймгийн төвийн дулааны станцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан "Бьюксанинженеринг" LLC, туслан гүйцэтгэгчээр "Энергосервисмонтаж" ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөхөөр газар шорооны ажил эхлэн ажиллаж байна. | 30 |
| 3.5.1.3 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн төвийн 2-р хэлхээний шугам сүлжээний ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2022 | - | Хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн эсэх тийм-1 үгүй-0 | 2020 | 0 | 1 | Ажлын зураг, төсөв боловсруулан магадлалаар хянагдан "10 аймгийн төвд дулааны станц барих төсөл"-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжид 1 хувь хүлээлгэн өгсөн. 2023 оны улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна. Төсөвт өртөг нь 36 тэрбум төгрөг. | 0 |
| 3.5.1.4 | <u>Арга хэмжээ:</u> Эрчим хүч хэмнэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх | 2021-2024 | 135.4 ОНТ | Хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн | 2020 | 2 | 1 | 2022 оны орон нутгийн төсөвт 4 төсөл арга хэмжээнд 353 сая төгрөг баталсан. Үүнд: | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлуудын хөрөнгийг шийдвэрлэх | | | эсэх (тийм-1, үгүй-0) | | | | - Биеийн тамир спортын газрын барилгын дээврийн засварын ажлыг Мандал Өргөө Голомт ХХК-тай 135,418,820 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.<br>- ТХДЖТеатрын барилгын пасадны засвар ажлыг Хангда ХХК-тай 39,997,746 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.<br>- "Бүрдийн уянга" хүүхдийн зуслангийн дээврийн засвар ажлыг Мандал шилтгээн ХХК-тай 148,134,854 төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.<br>- Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна фасад, дээврийн засварын зураг, төсөв боловсруулах ажлыг Люкс Товер ХХК-тай 12,230,000 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. | |
| 3.5.1.6 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн төвийн шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдын төвийн цахилгааны хангамжийг сайжруулах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021-2022 | 361.0 ТӨХК | Тухайн жилд хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн ажлын тоо | 2020 | 0 | 1 | Дэлхийн банкны хөрөнгөөр "Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100% шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих" ажлыг "Проект ватт" ХХК-тай 4,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 80 хувьтай.<br>Мөн 2022 оны улсын төсвийн хөрөнгөөр "Проектватт" ХХК-ийн "Багц-4: Дундговь, Хулд, Өлзийт сум; Дундговь, Луус сум"-ын барилга угсралтын ажлыг 2,583,599,270 төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Бэлтгэл ажил хийгдэж байна.<br>Хулд сумын 0,4кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний ажил ашиглалтад орсон. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | Зорилт: Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2024 онд 5386.1 сая төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | - | Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ (сая/төг) | 2019 | 5328.6 | 5363.1 | Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 3300,1 сая төгрөг байна. | 0 |
| 3.6.1.2 | Арга хэмжээ: Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах | 2021-2024 | - | Холбогдох байгууллагатай хамтарч ажилласан эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 0 | 1 | Зам, тээврийн хөгжлийн яаманд хэвтээ ба босоо авто замын ойролцоо олон улсын тээвэр логистикийн төвийг байгуулах төслийн саналыг хүргүүлсэн. | 0 |
| 3.6.1.3 | Арга хэмжээ: Мандалговь-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу үүрэн телфоны сүлжээ бий болгох. | | 60,0 | Үүрэн телфоны сүлжээний тоо | 2020 | 0 | 1 | Тус аймгийн улсын чанартай авто зам дагуу Дэрэн сумын Сайн төгрөгийн усны зүүн талд үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлж, ашиглаж эхэлсэн. | 100 |
| 3.6.1.4 | Арга хэмжээ: Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021-2024 | 2,500.0 УТ<br>392.7 ОНТ | Хөрөнгийн асуудал шийдвэрлэн хяналт тавьсан эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 1 | 1 | 2022 оны улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажлыг Дундговь авто зам ХХК-тай 2,883,879,285 төгрөгийн гэрээ байгуулан арчилгааны ажил хийгдэж байна.<br>2022 оны замын сангийн хөрөнгөөр 2 төсөл арга хэмжээний ажил баталсан. Үүнд:<br>Номгоноос Өлзийтмандал хүртэлх автозам, явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны тохижилтын ажил – 497,243,937 төгрөгийн ажлыг "Буянцогт зам" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.<br>Аймгийн төвийн 19км орон нутгийн авто замын засварын ажил - 349,628,989 төгрөг. Ажлын зураг, төсөв боловсруулах ажлыг хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Зорилго:** Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 65.8 хувьтай байгааг 2024 онд 78.6 хувьтай болгож нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| **4.1.1** | **Зорилт:** Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Хандив 20,0 | Тухайн жилд хэрэгжсэн цахим шилжилтийн хэрэгжилтийн хувь | 2020 | 20 | 85 | Орон нутгийн шинж чанартай 64 үйлчилгээг "И-монголиа" төрийн цахим үйлчилгээний системд нэвтрүүлсэн. "И-Монголиа" УТҮГ-тай хамтран "Цахим аймаг-Дундговь" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа ерөнхий консулын газартай хамтран 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "И-Монголиа" үйлчилгээний цэгийг байгуулж, иргэдэд төрийн цахим үйлчилгээг үзүүлж байна. Тоон бичиг үсэгтэн зорилтын хүрээнд 400 орчим төрийн албан хаагчдад мэдээллийн аюулгүй байдал цахим ур чадварын сургалтын зохион байгууллаа.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсыг шинэчлэн, шинээр 15 сумдыг цахим хуудастай болгож, аймгийн dundgovi.gov.mn цахим хаяг болон сумдын xxx@сумын нэр.du.gov.mn цахим хаягийн системийг шинэчлэн Zimbra систем рүү шилжүүлж, 1800 төрийн албан хаагчийн албаны цахим хаягийг баталгаажуулж төрийн албаны цалингийн системд холболоо.<br>Сумдын "И-Монголиа" операторын хэвийн үйл ажиллагааг хангаж, тоон гарын үсэг олох ажлын зохион байгуулж 15 сумын 16 төрийн үйлчигээний операторт тоон гарын үсгийг олголоо. Үүний үр дүнд төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эргэх холбооны чадавх 2022 оны байдлаар 100% болсон. | |
| 4.1.1.1 | **Арга хэмжээ:** "Цахим аймаг-Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 60,0 | Хэрэгжилтийн хувь | 2020 | 10 | 40 | "Цахим аймаг-Ухаалаг Дундговь" цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 8 арга хэмжээний хүрээнд төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн. Үүнд: "Цахим аймаг-Ухаалаг Дундговь" системийг хөгжүүлэлтийг гүйцэтгэгч "Боди электроникс" компанитай хамтран зохион байгуулж, 4 удаагийн уулзалт хэлэлцүүлэгийг хийж аймгийн төрийн байгууллагуудын ажлын тайлагналт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь цахимаар явуулах нөхцөл боломжоор хангалаа. Иргэдийн төрийн үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлж орон нутгийн шинж чанартай 64 үйлчилгээг и-монголиа төрий цахим үйлчилгээний системд нэвтрүүлсэн. "И-Монголиа" УТҮГ-тай хамтран "Цахим аймаг-Дундговь" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, нийтдээ 700 гаруй иргэдэд, төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 4.1.1.2 | **Арга хэмжээ:** Сумдыг 4G сүлжээтэй болгох. | | | 4G сүлжээтэй болсон сумдын тоо | 2020 | 0 | 5 | Аймгийн 15 сум бүгд 4G сүлжээтэй болсон. Дэрэн сумын Сайн төгрөгийн усны зүүн талд үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлж, мөн Өлзийт сумын Буянт баг, Эрдэнэдалай сумын Рашаант баг, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газруудад 4G сүлжээг нэвтрүүлсэн. | 100 |
| 4.1.1.3 | **Арга хэмжээ:** Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх | 2021-2024 | | Хамрагдсан иргэдийн тоо | 2020 | 0 | 5000 | "Хүний хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын хүрээнд иргэдэд хүргэх төрийн | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уулзалт, арга хэмжээг улирал бүр зохион байгуулах | | | | | | | үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллээр хангах уулзалт, арга хэмжээг зохион байгуулах аймгийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу 15 суманд малчдын зөвлөгөөн зохион байгуулж 3400 малчин иргэн хамрагдлаа. Аймгийн Засаг дарга төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэж, олон нийтийн санал хүсэлтийг сонсож, цаашдын бодлого төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх зорилгоор 11 дүгээр сарын 11,12 ны өдрүүдэд иргэдтэй уулзалт зохион байгуулж 600 гаруй иргэд оролцлоо. "Орон нутаг дахь төрийн албаны бүтээмж" сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж 300 гаруй төрийн албан хаагчидтай хэлэлцүүлэг зохион байгууллаа. Нийт 4300 иргэнийг хамруулаад байна. | |
| 4.1.1.4 | Арга хэмжээ: Төрийн архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх | 2021-2024 | - | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хувь | 2020 | 90 | 92 | Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд нийт 36 хөмрөгийн, 630 хадгаламжийн нэгж, 73376 хуудас баримтыг цахим санд оруулаад байна. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлснээр удирдлагын баримт тус онд 92 хувьд хүрсэн. | 100 |
| 4.1.1.5 | Арга хэмжээ: Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах | 2021-2024 | ОНТ 19.0 | Нягтруулсан шүүгээ болон бусад тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2020 | 50 | 80 | Төрийн архивд баримт хадгалах зориулалтын 7,5 сая төгрөгийн үнэ бүхий 16 нягтруулсан шүүгээ, хадгаламжийн 2 санд 1,5 сая үнэ бүхий хяналтын камер, 8,0 сая төгрөгийн агааржуулалтын систем суурилуулсан ба нийт 19,000 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж, баримт бичгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хадгалалт хамгаалалтыг сайжруулах хангалт 80%-д хүрээд байна. | |
| 4.1.1.7 | Арга хэмжээ: Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ" систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгах | 2021-2024 | - | -Тухайн жилд зөрчилгүй болсон иргэний тоо | 2020 | 8200 | 2050 | "Гэрэгэ" киоск төлбөрийн машиныг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлж төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломж бүрдэж тус оны эхний хагас жилийн байдлаар 1923 иргэн гэрэгэ төлбөрийн системээр улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийсэн байна. Эрдэнэдалай, Дэрэн сумдын ЗДТГ орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгийг шийдвэрлэн Гэрэгэ систем нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн төрөлтийн бүртгэлд овог, эцэг эхийн нэр, бүртгэлийн дугаар зөрүүтэй бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг анхан шатны журнал бүртгэл иргэдийн гар дээр байгаа бичиг баримтад үндэслэн жагсаалтаар иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн мэдээллийн санд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан үр дүн гарав. | 100 |
| | | | | | | | | | |
| **4.2** | Зорилго: Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна. | | | | | | | | |
| 4.2.1 | Зорилт: Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна. | 2021-2024 | - | томилгооны зөрчлийн бууралт хувь | 2020 | 33.2 | 18.3 | Томилгооны зөрчилтэй томилогдсон 64 албан хаагчийн томилгооны зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжилт 85.9%-тай байна. Аймгийн Засаг даргаас томилогддог Орон нутгийн өмчийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газрын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дарга нарын томилгооны зөрчил арилаагүй. Нийгмийн даатгалын хэлтсийн бичиг хэрэг, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал эмнэлгийн газрын Өндөршил сум хариуцсан мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч 2 жирэмсний амралттай байгаа. Сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын хүний нөөцийн томилгоонд салбар зөвлөлийн гишүүд хяналт шалгалт зохион байгуулла. Шалгалтаар илэрсэн 22 зөрчилтэй ажлын байрны судалгааг гарган томилгооны зөрчлийг 90.9% арилгуулла. Хулд сумын ЗДТГ 2 албан хаагчийн томилгооны зөрчлийг арилгаагүй. Аймгийн нийт дүгээр Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилт 87.2%-тай хэрэгжлээ. Ингэснээр аймгийн хэмжээнд төрийн захиргааны албан хаагчийн томилгооны зөрчил 22.5% байсныг 2.8%-д хүргэж 19,7 хувиар бууруулсан байна. | |
| 4.2.1.1 | **Арга хэмжээ:** Төрийн албан хаагчдыг шатлан дэвшүүлэх зарчмыг баримтлах | 2021-2024 | - | Тухайн жилд шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь | 2020 | 0 | 2 | Төрийн албаны тухай хууль болон чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн нийт төрийн захиргааны албан хаагчдын 2 хувь буюу 58 төрийн албан хаагчийг дэвшүүлэн ажиллуулсан. 2020 оноос хойш нийт төрийн жинхэнэ албан хаагчийн 16.1 хувийг шатлан дэвшүүлж ажиллуулсан байна. | 100 |
| 4.2.1.2 | **Арга хэмжээ:** Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд | 2021-2024 | ОНТ 11.3 | Богино болон дунд хугацааны сургалтад | 2020 | 46 | 138 | 2022 онд Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 13, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх | 92.4 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах | | | хамрагдсан албан хаагчдын тоо | | | | дунд хугацааны давтан сургалтад 20, төрийн албанд анх томилогдсон иргэнийг мэргэшүүлэх сургалтад 10, "Алсын хараа-2050" зайн сургалтад 8, "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, шинэчлэлт" зайн сургалтад 10, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" зайн сургалтад 9 хүн Аймгийн ЗДТГ-ын дарга нарт зориулсан "Нутгийн захиргааны байгууллагын удирдлага зохицуулалт" сэдэвт богино хугацааны зайн сургалтад 11, үр дүнд суурилсан удирдлага сэдэвт богино сургалтад 4 албан хаагч нийт 85 хүнийг богино болон дунд хугацааны сургалтад хамруулллаа.Ингэснээр аймгийн хэмжээнд нийт 131 төрийн албан хаагч богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | |
| 4.2.1.3 | <u>Арга хэмжээ:</u> Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийх | 2021-2024 | ОНТ 57.3 | Тухайн жилд гэрээ байгуулсан оюутны тоо | 2020 | 0 | 35 | ОХУ-ын Эрхүү мужийн А.А.Ежевскогын нэрэмжит Хөдөө аж ахуйн их сургуулийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт мэргэжлээр суралцсан 1, боловсрол салбарын ЕСБ болон СӨБ-ийн багшаар бэлтгэгдэж байгаа-6, Эрүүл мэндийн салбарт Хүний их эмч, сувилахуй мэргэжлээр суралцаж байгаа -6, хөдөө аж ахуй чиглэлээр суралцаг байгаа -4, инженер мэргэжлээр суралцаж байгаа-3, хууль эрх зүйн мэргэжлээр суралцаж байгаа1, соёл урлагийн салбарын -1, нийт 35 оюутантай гэрээ байгуулан орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчнийг бэлтгээд байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2 | Зорилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 2021-2024 | - | Шударга байдлын үнэлгээ хувь | 2019 | 69.8 | 72 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлига, хүнд сурталгүй "***Дундговь авлигагүй хөгжинө***" уриалгыг санаачлан хэрэгжүүлсний үр дүнд Авлигатай тэмцэх газраас 2 жил тутамд хийгддэг төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ 72.8 хувьтай дүгнэгдсэн нь өмнөх үеэс 3 функтээр нэмэгдсэн үр дүн гарсан. Төрийн албан хаагчдад шударга байдлыг төлөвшүүлэх зорилготой тус хугацаанд төрийн болон төрийн өмчит байгууллагын 1290 албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар хэлэлцүүлэг зохион байгуулан, АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар 2 пэйж хуудсанд 5044 төрийн албан хаагчийг нэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулав. ХАСУМ хянуулсан дүгнэлт/албан бичиг/-ийг аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт, ХАСУМ хянуулсан 20 дүгнэлтийг байршуулан ил тод нээлттэй сурталчилж шударга байдлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.2.2.1 | Арга хэмжээ: Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх. | 2021-2024 | - | Авлигаас урьдчилан сэргийлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хувь | 2019 | 80 | 85 | Аймгийн ЗДТГ-ын 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг иргэд, олон нийт, аймгийн төлөөлөгч нараас ирүүлсэн саналын дагуу 14 зорилт, 60 арга хэмжээтэй төлөвлөн боловсруулж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 90.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад дүгнэх хуудасны хамт хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, сургалтыг зохион байгуулан ажилласан. | |
| 4.2.2.2 | Арга хэмжээ: Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах. | 2021-2024 | - | ЭБАТ-ны сургалт, семинарт хамралтын хувь | 2019 | 80 | 100 | 2022 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны цахим семинар сургалтад төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах салбар 49 эрх бүхий албан тушаалтнуудыг 100 хувь оролцуулан чадавхжууллаа. | 100 |
| 4.2.3 | Зорилт: Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | Тухайн жилд эрх зүйн сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн хувь | 2019 | 10 | 13 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгуулах зорилт тавин сумдын “Эрх зүйн хөтөч”-үүдтэй хамтран ажилласны үр дүнд нийт 6415 иргэн буюу 13 хувьд эрх зүйн сургалт, сурталчилгаа туслалцаа үйлчилгээ үзүүлж ажиллалаа. | 100 |
| 4.2.3.1 | Арга хэмжээ: Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 2.2 | тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо | 2019 | 2 | 3 | Аймаг, сумдын “Эрх зүйн хөтөч”, “Насан туршийн боловсрол” зэрэг цахим хаягуудаар иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, Эрх зүйн хөтчүүдийг удирдлага зохион байгуулалтаар ханган сумдын ГХУСАЗЗ-ийн нарийн бичгийн дарга болон Эрх зүйн хөтөч нарыг давтан сургах ажлыг тус онд танхимын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэлбэрээр зохион байгуулав. Сумдын ГХУСАЗЗ, Эрх зүйн хөтөч нарын дунд иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах болзолт уралдаан зарлан ажиллаж байна. Аймаг, сумдын Эрх зүйн хөтчүүдээс эрх зүйн сургалтыг 118 удаа, сурталчилгааг 312 удаа зохион байгуулан 6736 хүн хамрагдаж эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, 133 төрлийн гарын авлага боловсруулан, аймаг, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим болон цаасан хэлбэрээр түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулав. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг "Сум бүрт" нээлттэй өдөрлөгөөр хууль хяналтын байгууллагууд хамтран Өлзийт, Дэлгэрцогт сумдад, мөн Өлзийт сумын Тагт, Буянт багийн малчдад "Малчны хотод" арга хэмжээг зохион байгуулан, иргэд, малчдад эрх зүйн боловсрол олгох, мөн "Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг"-ийг Эрдэнэдалай суманд тус тус зохион байгуулан нийт 354 хүнд эрх зүйн сургалтыг зохион байгуулсан. | |
| 4.2.3.2 | <u>Арга хэмжээ:</u> Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх | 2021-2024 | - | Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан СӨГ-ын шийдвэрлэлтийн өсөлт хувь | 2019 | 82 | 87 | Хууль хяналтын байгууллагууд хамтран "Хуульчийн Про боно" өдөрлөгийг зохион байгуулан 430 гаруй хүнд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч эрүүгийн 44 хэргийн төлбөрийн чадваргүй 49 холбогдогчдод хууль ёсны эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчөөр оролцож үйлчилгээ үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зөвлөгөөг 270 иргэнд үзүүллээ. Хүний эрхийн Үндэсний комиссын аймаг дахь ахлах мэргэжилтэнд 2022 онд санал, өргөдөл, гомдол ирээгүй байна. | |
| 4.2.3.3 | Арга хэмжээ: Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах | 2021-2022 | Төсөл 8.5 | Сургалтад хамрагдсан удирдлага, албан хаагчдын тоо | 2020 | | 20 | Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтад 200 албан хаагч хамрагдсан ба 2 дахь шатны танхимын сургалтад 30 албан хаагч хамрагдаж сертификат гардан авч 10 бичил төслийг хамтран хэрэгжүүлж байна. Танхимын сургалтад 30 албан хаагч хамрагдсанаас 16 нь удирдах ажилтнууд байна. Мөн хүйсийн харьцааг харвал эрэгтэй албан хаагч 14 эмэгтэй албан хаагч 16 хамрагдсан. | 100 |
| 4.2.3.4 | Арга хэмжээ: "Жендэрийн эрх тэгш байдал" тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 8,4 | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 2020 | 0 | 1 | Эерэг өөрчлөлт-эмэгтэйчүүдийн оролцоо зөвлөгөөнийг эмэгтэйчүүдийн холбоотой хамтран, Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал арга хэмжээг Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн Дундговь аймаг дахь салбартай хамтран зохион байгуулж, нийт 300 эмэгтэй, 216 эрэгтэйчүүдийг хамрууллаа. Мөн 7 бичил төсөл амжилттай хэрэгжүүллээ. | 100 |
| **4.3** | Зорилго: Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2019 онд 86.5 байсныг 2024 онд 90-ээс дээш хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| 4.3.1 | Зорилт: Гэмт хэргийн гаралт 2019 онд 266 байсныг 2024 онд 10-аас доошгүй хувиар бууруулна. | 2021-2024 | - | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | 2019 | 266 | 253 | Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 онд 247 гэмт хэрэг бүртгэгдсэн. | 100 |
| 4.3.1.1 | Арга хэмжээ: Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай | 2021-2024 | - | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг (тоо) | 2019 | 55 | 50 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар "Мэргэжилтний баг" байгуулагдан үйл ажиллагаагаа | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцэх орон нутгийн бодлого боловсруулан, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | | | | | | | эхлүүлж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр "Говийн хийморь" бүлгийн гишүүд, ахлагч нартай уулзалт ярилцлага зохион байгуулж, архинаас татгалзан 25 хүн уг цуглаанд тогтмол хамрагдаж байна. "Архигүй амьдралыг цогцлооё-Архигүй төрийн алба" аяны хүрээнд "Архи, согтууруулах ундааны нийгэм, гэр бүлд үзүүлэх хор нөлөө" сэдвээр сургалт мэдээлэл хийж, 1 удаагийн подкаст нэвтрүүлэг, 14 төрлийн зурагт хуудас, 2 төрлийн теле зохиомж бэлтгэн 1500 иргэд олон нийтэд хүргэсэн. Аймгийн холбогдох байгууллагуудтай хамтран "Гэмт хэргээс урьдчилан ажлыг сум бүрд" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулан 5 сумын 450 иргэнд "Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ" сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн. Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон 4 иргэнд шүүхийн шийдвэр гаргуулан, архины албадан эмчилгээнд хамруулсан.<br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг аймгийн хэмжээнд 96 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 буюу 7.87 хувиар өссөн. | |
| 4.3.1.2 | <u>Арга хэмжээ:</u> Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021-2024 | - | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2019 | 4 | 12 | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, "Оюуны | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэгээ", "Гэрэлтдэг ертөнц", "Дүүрэн бэлэг" ТББ, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран "Ахлагч ба нэг бүрчилсэн хяналт", "Хяная шалгая", "Илрүүлье", "Иргэн бүр мэдээлэгч байя" "Сэрэмжилье", "Хүүхдийн аюулгүй байдал бидний оролцоо", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлье", "Хуулиа мөрдье", "Гэр бүлээ хайрлая", "Хувь хүний хөгжил", "Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг", "Хамтарсан багаараа хамгаалъя", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сум бүрд", "Хамтдаа", "Сэтгэлийн мянган аялал" зэрэг 15 төрлийн тусгай арга хэмжээг байгуулсан. | |
| 4.3.1.3 | <u>Арга хэмжээ:</u> Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | 2021-2024 | - | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бууралт (тоо) | 2019 | 16 | 12 | Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр "Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод" зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлсэн. Энэ төрлийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж олон нийтийн сүлжээнд байршуулсан. Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Ногоон гэрэл Цагаан шугам 2022" тэмцээнийг аймгийн Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ- | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тэй хамтран амжилттай зохион байгуулсан. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2022 онд 18 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 нэгжээр буюу 10 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 4.3.1.4 | Арга хэмжээ: Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага, оролцоотой томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх | 2021-2024 | 50.0 Улсын төсөв | Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт (хувь) | 2019 | 32,5 | 35 | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Баянжаргалан суманд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэхээр 20 сая төгрөгийг шийдвэрлэн тендер зарлаж, сумыг төвийг хяналтад авах 4 цэгт, 4 ширхэг PTZ теле камер байршуулан ашиглаж байна. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлж, 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр Мандалговь хотыг бүрэн камержуулах зураг, төслийн ажилд шаардлагатай 30 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгуулан тендерт шалгарсан “Сителком” компани зураг төслийн ажлыг хийж дуусгасан. Иргэдийн хувийн өмчийг хулгайлах гэмт 2022 онд 39 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 нэгж буюу 9.30 хувиар, үүнээс хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 6 нэгж буюу 14.63 хувиар буурсан, авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 2 нэгж буюу 2 дахин өссөн. Хулгайн гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 47.2 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.1.5 | Арга хэмжээ: Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах | 2021-2024 | 1.2 ОНТ | Мал хулгайлах гэмт хэргийн бууралт (тоо) | 2019 | 29 | 26 | Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 10 бүртгэгдсэн. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 5 сумдын малчдыг хамруулан малчдын зөвлөгөөнийг 1 удаа зохион, мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 1 удаа сургалт, 8 суманд зохион байгуулагдсан "Малчдын өдөр" өдөрлөгт 8 удаа яриа таниулга хийж нийт 3800 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан. | 100 |
| 4.3.2 | Зорилт: Гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 49.4%-тай байсныг 2024 онд 55-аас дээш хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | Гэмт хэргийн илрүүлэлт (хувь) | 2020 | 49.4 | 51.5 | Аймгийн хэмжээнд 2022 онд 247 гэмт хэрэг бүртгэгдсэн ба гэмт хэргийн илрүүлэлт 59.4 хувьтай, улсын хэмжээний илрүүлэлтийн дунджаас 5.2 хувь өндөр байна. | 100 |
| 4.3.2.1 | Арга хэмжээ: Аймгийн Цагдаагийн газрын автопарк болон алба хаагчдын 25-аас доошгүй хувийн хэт богино долгионы радио холбоог шинэчилж, албан хэрэгцээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах | 2022 | - | Цагдаагийн байгууллагын машин, техник, тоног төхөөрөмжийн хангалт хувь | 2019 | 46 | 90 | Цагдаагийн албаны шуурхай байдлыг хангах зорилгоор аймгийн төв болон суманд 21 автомашин, 10 мотоциклтой үүрэг гүйцэтгэж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломж аюулгүй байдлыг хангах зорилгоор энгэрийн 7 камерыг шийдвэрлэсэн. Хангалт 90 хувьтай байна. | 100 |
| | | 2021-2024 | 12,7 ОНТ 7,0 УТХО | Радио холбоогоор хангагдсан албан хаагчдын эзлэх хувь | 2020 | 30 | 50 | Нийт алба хаагчдын 45.1 хувь нь радио холбоогоор хангагдаад байгаа ба мөн албаны автомашины 63 хувь нь хэт богино долгионы радио станцаар хангагдсан нь 54 хувийг эзэлж байна. Сайнцагаан сумын Гэмт хэргээс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 6, мөн богино долгионы радио холбооны нөөц тэжээл 20 ширхэг, дахин дамжуулах станц зэрэг 19.700.000 төгрөгийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийг шийдвэрлэсэн. | |
| 4.3.2.3 | Арга хэмжээ: Аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх байрыг сайжруулж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэн хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх | 2022-2023 | 2,3 УТХО | Эрүүлжүүлэх байрны Монгол Улсын стандарт MNS 5527:2019 шаардлага хангасан хувь | 2020 | 10 | 50 | Тус байранд Цагдаагийн газрын дотоод нөөц бололцоонд тулгуурлан орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 1.8 сая төгрөгийн өртөг бүхий засвар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2.3 сая төгрөгийг шийдвэрлүүлж агааржуулах төхөөрөмж суурилуулан агаарын солилцоог сайжруулж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлж ажилласан. Эрүүлжүүлэх байрны Монгол Улсын стандарт MNS 5527:2019 шаардлагыг 20 хувьтай хангаад байна. | 25 |
| 4.3.3 | Зорилт: Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдал 2020 онд 60 хувьтай байсныг 2024 онд 73 хувьд хүргэнэ. | 2021-2024 | ОНТ 10.0 | Гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын хувь | 2020 | 60 | 68 | Хулд суманд Эрэн хайх аврах бүлэг байгуулагдсантай холбоотойгоор орон нутгаас байрны асуудлыг шийдвэрлэж 10.0 сая төгрөгөөр бүлгийн байрны засварыг хийж үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж 2022 оны 10 дугаар сараас 07-ний өдрөөс Эрэн хайх, аврах бүлгийг томилон ажиллуулсан. Тус бүлэг нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гал түймрийн болон эрэн хайх, аврах ажиллагааны 3 удаагийн дуудлагаар гарч ажиллан 2 хүний амь нас, иргэдийн 98.3 сая төгрөгийг эд хөрөнгийг авран хамгаалсан бөгөөд тус бүлгийг шинээр байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлснээр албаны гамшигтай тэмцэх | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бэлтгэл бэлэн байдал 69.5 хувьтай хангагдаад байна. | |
| 4.3.3.1 | <u>Арга хэмжээ:</u> Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах техникийн бэлэн байдлыг хангах | 2021-2024 | ОНТ 1.6 | Утасны эрх сэргээсэн малчдын тоо | 2020 | 14 | 14 | Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, цаг агаарын нөхцөл байдлыг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор "Аюулаас сэрэмжлүүлэх цогцолбор"-ийн толгойн сэргийлэх 15 малчин өрхийн утасны эрхийг жилийн хугацаатай нийт 1,602,000 төгрөгөөр сэргээсэн бөгөөд малчид иргэдэд цаг агаарын сэрэмжлүүлгийг шуурхай хүргэх нөхцөлийг хангуулсан. | 100 |
| | | 2021-2024 | | Сэрэмжлүүлэг мэдээ, зөвлөмж дамжуулсан тоо | 2020 | 6 | 10 | 2022 оны 11 дүгээр сарын байдлаар УЦУОШТ, ОБЕГ -аас 16 удаагийн цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ хүлээн авч иргэд, толгойн сэргийлэх малчид, аймаг сумын онцгой комиссын гишүүд, сумын удирдлагууд, багийн дарга нар нийт 5500 хүнд, 20 удаагийн багц мессеж хүргэж, давхар үүрэн холбооны утсаар залгаж мэдээлэл хүргэсэн. Албаны цахим хаяг, фейсбүүк хуудсаар 30-35 удаагийн мэдээллийг ард иргэдэд дамжуулж давхардсан тоогоор 950.000 хүргэж урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. | |
| 4.3.3.2 | <u>Арга хэмжээ:</u> Гамшгаас хамгаалах ангиллын сургалтанд орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах | 2021-2024 | - | Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | 2020 | 12 | 20 | Ард иргэдэд аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдлэгийг хүргэх зорилгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн байдлаар нийт 480 удаа зохион байгуулж 9200 иргэнийг буюу нийт хүн амын 19,5 хувийг хамруулаад байна. | 93.7 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.3.3 | Арга хэмжээ: Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах | 2021-2024 | - | Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо | 2020 | 6 | 6 | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу нийт 15 сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2022 оны 05 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд, гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Луус, Гурвансайхан, Өндөршил сумдад 10 дугаар сарын 26-27-ний өдрүүдэд, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Хулд суманд 11 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулсан. | 100 |
| 4.3.3.4 | Арга хэмжээ: Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслээр хангах | 2021-2024 | - | Ажлын байр, хүний нөөцийн нөхөн хангалтын хувь | 2020 | 0 | 70 | Хулд суманд Эрэн хайх аврах бүлэг байгуулагдсантай холбоотойгоор орон нутгаас байрны асуудлыг шийдвэрлэж 10.0 сая төгрөгөөр бүлгийн байрны засварыг хийж үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж 2022 оны 10 дугаар сараас 07-ний өдрөөс Эрэн хайх, аврах бүлгийг орон тооны 80 хувийн бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсан. Тус бүлэг нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гал түймрийн болон эрэн хайх, аврах ажиллагааны 3 удаагийн дуудлагаар гарч ажиллан 2 хүний амь нас, иргэдийн 98.3 сая төгрөгийг эд хөрөнгийг авран хамгаалсан. | 100 |
| | | 2021-2024 | Төсөл 66.5<br><br>ОНТ 35.0 | Техник хэрэгсэл, багажын хангалтын хувь | 2020 | 0 | 70 | Хулд сумын Эрэн хайх аврах бүлэг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Бүгд Найрамдах Турк улсын Онцгой байдлын албанаас ирүүлсэн тусламжийн хөрөнгөнөөс тус аврах бүлэгт 11 ширхэг 66,536,000 төгрөгийн аврах ажиллагааны багажийг худалдан авсан. Мөн орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас шинээр байгуулагдсан Хулд сумын Эрэн хайх, аврах бүлэгт орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 35.0 сая төгрөгийн 82 инчийн дэлгэц, иж бүрэн компьютер, принтер, гамшгийн үеийн харилцаа холбоог зохион байгуулах гар радио станц, энгэрийн камер зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжийг олгосон Ингэснээр техник, багаж хэрэгслийн хангалт 75 хувьтай хангагдаад байна. | |
| | **4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого** | | | | | | | | |
| 4.4.1 | Зорилт: БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 онд 500 сая төгрөг байсныг 2024 онд 900 сая.төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | - | Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ (сая.төг) | 2020 | 500.0 | 700.0 | 2022 онд БНХАУ,Солонгос,Япон Улсын муж хотууд,Канад, АНУ-ын санхүүжилттэй олон улсын болон төрийн бус байгууллагууд, Монгол Улс дахь Элчин сайдын яамдтай хамтран 15 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн орон нутгийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт 1,972,945,563 төгрөг байна. | 100 |
| 4.4.1.1 | Арга хэмжээ: БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай гадаад хамтын ажиллагааны хүрээнд тусгасан ажлуудыг шат дараалалтайгаар зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 0,5 | Хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын тоо | 2020 | 0 | 3 | 1.БНХАУ-ын Шанси мужаас зохион байгуулсан "Өвлийн олимпын үзэл санааг сурталчлах" олон улсын уран зургийн үзэсгэлэнд 14 хүүхэд оролцсон.<br>2.Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд, аймгийн Засаг дарга нар 321,508,182 төгрөгийн өртөг бүхий Эрдмийн далай цогцолбор сургуулийн засварын гэрээг байгуулсан.<br>3. Япон, Монгол Улсын хамтарсан "Тохоку Монгол" төрийн бус байгууллагатай хамтран сурагчдад тус бүр 700,000 төгрөгийн өртөг бүхий 50 ширхэг цүнх(35 сая төгрөг) хандивласан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 4. БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас 63,000,000 төгрөг хандивласан.<br>5. БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас зохион байгуулсан цахим форумд оролцон орон нутаг хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр илтгэл тавьсан. | |
| 4.4.1.2 | Арга хэмжээ: БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг ханган жилд 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах | 2021-2024 | Ногоон Ази ТББ-ын санхүүжилт 60,0 | Санамж бичгийн хэрэгжилтийн хувь | 2020 | 40 | 55 | БНХАУ-ын Баяннуур аймагтай ковид нөхцөл байдлын улмаас хэрэгжүүлэх арга хэмжээ хойшлогдсон.<br>БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд Гуяны төглийн 4, 5 дугаар талбайд 10,000 дуслын системийг нэмэгдүүлсэн. 2022 онд байгуулсан санамж бичгийн хэрэгжилт 66,6 хувьтай байна. | 100 |
| 4.4.1.3 | Арга хэмжээ: Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Гадаад улсад туршлага судлах сургалт арга хэмжээнд хамруулах | 2022-2024 | - | Тухайн жилд туршлага судлах албан хаагчдын тоо | 2019 | 51 | 20 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3.-т заасны дагуу туршлага судлах арга хэмжээнд орон нутгийн зардлаар албан хаагчдыг биечлэн оролцуулах боломжгүй байна. Дээд газрын төлөвлөгөөний дагуу БНСУ, Япон Улсад 2 албан тушаалтан туршлага судлах арга хэмжээнд оролцон, Зүүн хойд Азийн Нутгийн Захиргаадын холбоонд 1 ажилтан томилогдон ажиллаж байна. Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын холбооноос зохион байгуулсан цахим сургалтад хоёр албан хаагч хамрагдан нийт 5 албан хаагч туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан. Сайнцагаан сумын ЭДЦС-ийн 2 багш Английн International House of London байгууллагын 2 сарын мэргэжил | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дээшлүүлэх цахим сургалт, Цэгцбилиг сургуулийн орос хэлний багш Санктпетер бургин их сургуулийн ТРКИ сургалтад, аймгийн БШУГ-ын 1 мэргэжилтэн Солонгос улсад цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах сургалтад тус тус хамрагдаж гэрчилгээ авч, ажлын байрнаасаа гадаад орны туршлагаас суралцсан ажил болов. Гадаад хэлний 12 багшийг зуны амралтаар нь мэргэжил дээшлүүлэх вакум сургалтад хамруулсан. ОХУ-ын Эрхүү мужийн А.А.Ежевскогын нэрэмжит Хөдөө аж ахуйн их сургуулийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт мэргэжлээр суралцсан. Нийт 23 албан хаагч биечлэн болон цахимаар суралцаж чадавхжлаа. | |
| 4.4.1.4 | Арга хэмжээ: Улаанбаатар хот дахь ОШУСТ-тэй хамтран жил бүр ОХУ-ийн ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрт багш, сурагчдыг хамруулан ажиллах | 2021-2024 | ОНТ 0,5 | Оролцсон багш, сурагчдын тоо | 2020 | 2 | 6 | 2022 онд Засаг даргын нөөц сангаас дэмжлэг үзүүлэн ЕБС-ийн сурагч, багш нар орос хэлний бүсийн олимпиадад оролцон ОХУ-д 100% тэтгэлгээр суралцах эрхээр 1 сурагч, үнэ төлбөргүй мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах эрхээр 1 багш, дууны төрөлд тусгай байранд 1 сурагч шалгарсан. Нийт ОХУ-ийн ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрт 6 сурагч, 4 багш хамрагдаад байна. | 100 |
| 4.5.1 | Зорилт: Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний онцгой нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадамж 2020 онд 80 хувь | 2021-2024 | ОНТ 4.1 | Цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөлтийн онол, дадлагын бэлтгэлийн хувь | 2020 | 80 | 84 | 2022 оны цэргийн бүртгэлийн үеэр сумдын тоо бүртгэл явуулах комисс 15 сумын орон нутгийн хамгаалалтын отрядын бүрэлдэхүүний тодотгол хийсэн. Цэргийн штабын 2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургалтыг 05 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байсныг 2024 онд 88 хувьд хүргэнэ. | | | | | | | дугаар сарын 21-27-ныг дуустал 33 хүнтэйгээр онол, дадлагыг явуулж 100 хувь хэрэгжүүлэн ажиллаа. | |
| 4.5.1.1 | <u>Арга хэмжээ:</u> Ахлах ангийн сурагчдад "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах | 2021-2024 | - | Сургалтад хамрагдсан сурагчдын хамрагдалтын хувь | 2020 | 30 | 70 | 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын үеэр Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын ЕБС-ийн ахлах ангийн 350 гаруй сурагчдыг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын үеэр Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдын 1199, нийт 1549 ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг **100** хувь хамруулан "Эх оронч" үндэсний хөтөлбөрийг сурталчилсан. | 100 |
| 4.5.1.2 | <u>Арга хэмжээ:</u> Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалтын тогтолцоог бэхжүүлэх, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэн нөөцийг бүрдүүлэх | 2021-2024 | - | Дайчилгааны бэлэн байдлын нөөцийн хувь | 2020 | 100 | 100 | 4х6 хэмжээтэй асар 2 ком, Нягтруулгатай сейф 1 ширхэг тус тус худалдан авснаар дайчилгааны бэлэн байдлын нөөц 100 хувьтай байна. | 100 |
| 4.5.1.3 | <u>Арга хэмжээ:</u> Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах. | 2021-2024 | - | тухайн жилд зохион байгуулах сургалтын тоо | 2020 | 2 | 2 | Батлан хамгаалах яамнаас сургалт явуулахыг хориглосон. | 0 |
| 4.5.1.4 | <u>Арга хэмжээ:</u> Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг тухайн жилийн орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах | 2021-2024 | ОНТ 3.5 | Бүтээн байгуулалтын ажилд оролцсон иргэдийн тоо | 2020 | 35 | 30 | 2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2021, 2022 оны цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч иргэдийг зарлан дуудаж, 2022 оны 7 дугаар сарын 22-ноос 8 дугаар сарын 04-ныг дуустал 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн байрлалд зохион байгуулан явуулсан. Дундговь аймаг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл, орон нутагт явагдсан 1 түмэн мод тарих ажилд модны нүх ухах, зэрлэг зулгаах, бүтээн байгуулалтын ажлуудад оролцож, тохижуулах арга хэмжээний бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэн ажилсан. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч иргэдийн аймгийн нөөц өвс, тэжээл хадгалах байрт 2 хоног өвс хураах, тэжээл савлах ажлуудад, ойр орчмын ил хаягдсан хог-байгаль орчноо цэвэрлэж ард иргэдэд үлгэр дуурайлал үзүүлэв. Бүтээн байгуулалтын ажилд 35 цэргийн дүйцүүлэх алба хаагч иргэдийг хамруулсан. | |
| | | | | | | | | | |
| **5.1** | Зорилго: Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 5.1.1 | Зорилт: Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээ 2024 он гэхэд 4 хувиар бууруулна. | 2021-2024 | - | Төв суурин газрын орчны бохирдлын түвшний бууралтын хувь | 2020 | 1 | 3 | Төв суурин газрын орчны бохирдлыг бохирдуулагч эх үүсвэрийн бууралтын хувиар дундажлан тооцдог. Гэр хороололд 7 сайжруулсан ариун цэврийн байгууламж, нам даралтын уурын зууханд 8 ширхэг уутат шүүлтүүр нэмэгдэж төв суурин газрын орчны бохирдлын хэмжээ 3.8 хувиар багассан үзүүлэлттэй байна. | 100 |
| 5.1.1.1 | Арга хэмжээ: Агаарт агуулагдаж байгаа тоос тоосонцрыг хэмжих зөөврийн багажтай болж, 3 төрлийн бодисыг бүрэн хэмждэг болох | 2022-2024 | УТ 800.0 | Агаарын чанарын индексийн түвшин индекс | - | - | 100> | Аймгийн төвд жижиг оврын тоосонцрын багажтай болсноор 2022 оны 1 дүгээр сараас эхлэн агаарын жижиг ширхэгт тоосонцрыг /PM2.5/ тогтмол хэмжиж эхэлсэн бөгөөд агаарын чанарыг 3 төрлийн үзүүлэлтээр үнэлэхэд агаарын чанарын индекс 0-50 /100>/ буюу хүний | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, агаар цэвэр ангилалд багтаж байна. | |
| 5.1.1.2 | Арга хэмжээ: Утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх | 2022-2024 | УТ 608.5 | утаа бага ялгаруулдаг зуухны тоо | 2020 | 2 | 3 | Төвлөрсөн халаалтын 8 янданд утаа шүүгч байршуулах угсралтын ажил бүрэн дууссан. | 100 |
| 5.1.1.3 | Арга хэмжээ: Төв суурин газрын гэр хорооллын сайжруулсан зуухны тоог нэмэгдүүлэх | 2022, 2024 | Хувийн хэвшил 39.6 | Сайжруулсан зуухны өсөлтийн хувь | 2020 | 7.9 | 8.5 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын мэдээгээр төв суурин газрын гэр хорооллын сайжруулсан зуухны хэрэглээ 44-өөр нэмэгдэж төв суурин газрын гэр хорооллын нийт айл өрхийн 8.8 хувь нь сайжруулсан зуухаар хангагдсан. | 100 |
| 5.1.1.5 | Арга хэмжээ: Гэр хороолол болон аялал жуулчлал, уул уурхайн бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021-2024 | Хувийн хэвшил 7.9 | Эко ариун цэврийн байгууламжийн тоо | 2020 | 21 | 30 | Дэлгэрцогт суманд 1, Дэрэн суманд 4 өрх сайжруулсан ариун цэврийн байгууламж, Гурвансайхан суманд 2 өрх шинээр шаардлага хангасан бохирын шугамд холбогдлоо.<br>Гэр хороололд нийт 7 өрх ариун цэврийн байгууламжаа байгальд ээлтэй байдлаар шийдэж аймгийн хэмжээний эко жорлонгийн тоог 42 болгож нэмэгдүүлсэн. | 100 |
| 5.1.2 | Зорилт: Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2024 он гэхэд 46 тонн дахивар хогийг нийлүүлнэ. | 2021-2024 | - | Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ (тн) | - | - | 10 | Сайнцагаан суманд 8 тн, Сайхан-Овоо суманд 3.5 тн, Дэлгэрцогт суманд 2.5 тн, Луус суманд 3 тн, нийт 4 суманд 3 төрлийн 17 тн дахивар хог хаягдлыг дахивар нөөц авах цэгт цуглуулж, 11.2 тн хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэв. | 100 |
| 5.1.2.1 | Арга хэмжээ: Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах | 2021-2024 | ОНТ 65.2 | Шууж булшилсан талбайн хэмжээ (га) | 2020 | 7.4 | 12 | Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тохижилтын ажил Хулд суманд 0.2 га, Дэлгэрцогт суманд 0.2 га, Эрдэнэдалай суманд 7 га, Адаацаг суманд 1.5 га, | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Сайнцагаан суманд 4 га нийт 12.9 га газрыг шууж, булшлах ажил хийгдсэн. | |
| 5.1.2.2 | Арга хэмжээ: Аймгийн төвд ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх | 2021-2024 | ОНТ 22.1 Хувийн хэвшил 19.0 | Хогийн савны нэмэгдүүлсэн тоо | 2020 | 25 | 35 | Аймгийн хэмжээнд нийт 21 ширхэг ангилан ялгах хогийн сав шинээр бий болсноос аймгийн төвд 9 ААН, байгууллага ангилан ялгах хогийн сав байршуулж нийт Сайнцагаан суманд 41 болж нэмэгдэв. | 100 |
| 5.1.3 | Зорилт: Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 26.5 байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ. | 2021-2024 | УТ, ОНТ, БХНСА ХЗ 68.8 | Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь | 2020 | 26.5 | 28 | Дэлгэрхангай суманд 2 цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулснаар хүн амын 36.8 хувь нь шаардлага хангасан цэвэршүүлсэн ундны усны эх үүсвэрээр хангагдсан. | 100 |
| 5.1.3.1 | Арга хэмжээ: Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах | 2021-2024 | ОНТ 20.0 | Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо | - | - | 2 | Дэлгэрхангай суманд орон нутгийн хөгжлийн сангийн 20 сая төгрөгийн хөрөнгөөр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг сумын төвийн ундны усны 2 эх үүсвэр дээр суурилуулав. | 100 |
| 5.1.3.2 | Арга хэмжээ: Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2021-2024 | БХНСА ХЗ 4.8 | Хамгаалалтын бүс тогтоосон булгийн тоо | - | - | 30 | Тус аймгийн хэмжээнд усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор 160 булаг, нуур тойромд 40909,29 га усны сан бүхий газар нутгийг аймгийн ИТХурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 27 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дэлгэрхангай, Баянжаргалан, Сайнцагаан, сумдын нутагт усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд 37 тэмдэг, тэмдэглэгээг байршуулав. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.3.3 | <u>Арга хэмжээ:</u> Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах | 2022 | УТ 19.0 Хувийн хэвшил 3.0 | Шинээр байгуулсан хөв цөөрмийн тоо | - | 0 | 2 | Өлзийт сумын Буянт багийн нутаг "Жавхлант хайрхан" хэмээх газарт байрлах "Хөтөл ус"-ны энгийн уурхайн худгийг түшиглэн Улсын төсвийн хөрөнгөөр хөв цөөрөм байгууллаа. Зураг төсвийн дагуу 1000 мм голчтой 3 ширхэг кольцо суулган, 120 мм диаметртэй 42 метрийн урт ус дамжуулах хоолой суурилуулж, 4 $м^3$ эзлэхүүнтэй усан сан хийж гүйцэтгэлээ. Мөн Юнител группийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэрхангай уул", "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад зэрлэг амьтдад зориулсан хөв цөөрмийг байгуулав. | 100 |
| 5.1.3.4 | <u>Арга хэмжээ:</u> Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | 2021-2024 | БХНСА ХЗ 15.0 | Хашсан булгийн тоо | 2020 | 53 | 59 | Луус сумын "Зодохын булаг", Хулд сумын "Жирмийн булаг", Сайхан-Овоо сумын "Жарантайн булаг"-ийн эхийг хашин хамгаалж газрын даргын А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг актаар хүлээн авлаа. Тус булгуудыг хашиж хамгаалснаар 16 өрхийн бог, бод нийлсэн 10655 мал ундаална.<br>Нийт 59 булгийн эхийг хашиж хамгаалаад байна. | 100 |
| 5.1.4 | <u>Зорилт:</u> Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 413.4 га-д хүргэнэ. | 2021-2024 | УТ, ОНТ 108.0 | Ногоон байгууламжийн хэмжээ (га) | 2020 | 369.4 | 381.4 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Дундговио ногооруулъя" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 122884 мод, сөөг тарьж ургуулаа. "Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх" хөтөлбөрийн хүрээнд 8 га, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 5 га нийт 13 га газарт ойн зурвас байгуулж нийт ногоон байгууламжийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэмжээ 382.4 га болсон. | |
| 5.1.4.1 | <u>Арга хэмжээ:</u> Төв зам дагуу ногоон байгууламжийг бий болгох | 2022-2024 | ОНТ 5.5 | Ногоон байгууламжийн хэмжээ (га) | | 0 | 10 | Худалдааны гудамжны тохижилтын зураг төсвийг "Чанс" ХХК гүйцэтгэж зургийн дагуу Хот тохижуулах газар 96 хайрцагт 558 бортоготой мод тарьж хотын өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.<br>Төв зам дагуух ногоон байгууламжийн хэмжээ нийт 25.9 га-д хүрэв. | 100 |
| 5.1.4.2 | <u>Арга хэмжээ:</u> Аймгийн хэмжээнд 4 га талбайд ойн зурвас байгуулах | 2021-2024 | УТ, ОНТ 102.5 | тухайн жилд байгуулсан ойн зурвасын талбайн хэмжээ (га) | 2020 | 5 | 1 | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Өлзийт суманд 2 га, Дэлгэрхангай суманд 2 га, Говь-Угтаал суманд 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэж аймгийн Засаг даргын А/382 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа.<br>"Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх" хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэдалай суманд 8 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг "Тэнгэрлэг ой" ХХК гүйцэтгэж аймгийн ЗДТГазрын даргын А/240 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. | 100 |
| 5.1.5 | <u>Зорилт:</u> Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох | 2021-2024 | | Нөхөн сэргээсэн талбайн эзлэх | 2020 | 8.3 | 16.5 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувьд хүргэнэ. | | | хувь /өссөн дүнгээр/ | | | | сэргээсэн талбайн хэмжээ 16.6 хувийг эзэлж байна. | |
| 5.1.5.1 | Арга хэмжээ: Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 100 га-д хийлгэх | 2022-2024 | Хувийн хэвшил 110.4 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ га | 2020 | 79.64 | 104.6 | Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 6 сумын нутаг дэвсгэрт 9 талбар бүхий газарт 7.77 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.<br>Үүнд: Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газарт 5.31 га, хайгуулын улмаас эвдэрсэн талбайд 0.12 га, эзэнгүй эвдэрсэн газарт 2.3 талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийгдэж нийт нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 121.02 га-д хүрсэн. | 100 |
| 5.1.5.2 | Арга хэмжээ: Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 25 га-д хийлгэх. | 2021-2024 | Хувийн хэвшил 12.0 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ (га) | 2019 | 1 | 16 | Тус аймгийн 4 сумын нутаг дэвсгэрт 5 аж ахуйн нэгж 4.2 га талбайд мод бут, олон наст ургамал тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн, мөн эзэнгүй эвдэрсэн газрын тооллогын дүнг өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад Дэлгэрцогт сумын 14.54 га газар байгалийн аясаар ургамалжин нөхөн сэргээгдсэн үзүүлэлт гарсан. Нийт биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай 24.74 га-д хүрсэн. | 100 |
| 5.1.5.3 | Арга хэмжээ: Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулах. | 2022-2023 | БХНСА ХЗ 3.0 | Хохирол тооцуулсан хэмжээ (га) | 2019 | 100.4 | 120.4 | Хууль бус ашигт малтмалын улмаас эвдэрсэн 10.15 га газарт хохирлын үнэлгээ тооцуулах ажил 2022 онд хийгдсэн.<br>Аймгийн хэмжээнд нийт 110,55 га талбайд эдийн засгийн хохирлын үнэлгээ тооцуулав. | 51 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.6 | Зорилт: Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хувь | 2020 | 27 | 32.5 | Өлзийт сумын "Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга" орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авхуулахаар сум, аймгийн ИТХурлын 2019 оны тогтоол гаргаж хүргүүлсний дагуу 2022 оны 5 сард Улсын Их Хурлын байгаль орчин, аялал жуулчлалын байнгын хороо, БОАЖЯамны ТХБНУГазрын ажлын хэсэг газар дээр нь ажиллаж нөхцөл байдалтай танилцсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор "Сүм хөх бүрд" аймгийн тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж 32588.17 га талбайг улсын тусгай хамгаалалтад оруулах саналыг аймгийн Засаг даргын албан бичгээр БОАЖЯаманд хүргүүлэв. Ингэснээр улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 32.9 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүллээ. | 100 |
| 5.1.6.1 | Арга хэмжээ: Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах | 2022 | БХНСА ХЗ 6.8 | Улсын тусгай хамгаалалттай нутгийн хэмжээ | 2020 | 5.7 | 10.2 | "Сүм хөх бүрд" аймгийн тусгай хамгаалалттай 548.5 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 32588.17 га болгон улсын тусгай хамгаалалтад оруулахаар Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 37 дугаар тогтоол тус тус гаргуулж, албан бичгээр БОАЖЯаманд хүргүүлэв. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 5.7 хувиас 10.6 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.6.2 | **Арга хэмжээ:** Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргуулах | 2021-2024 | - | орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хувь | 2020 | 21.3 | 22.3 | Хулд сумын Олдохын хийд, Дэрэн сумын Бумбатын овоо, Бумбатын шорвог, Тэгшийн суурин орчмын сумын тусгай хамгаалалттай газруудын тогтоолыг шинэчилж газар нутгийг өргөтгөн сумын ИТХурлаар батлав. Ингэснээр орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 21.8 хувиас 22.3 хувь болж нэмэгдэв. | 100 |
| 6.1. | **Зорилго:** Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцаар 2020 онд 108 өрхийг хангаснаас 2024 онд 208 өрхийг нэмж хамруулна. | | | | | | | | |
| 6.1.1 | **Зорилт:** Иргэдийн оролцоотой "Шинэ сум" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд бүтэцтэй сум 2020 онд 2 байсныг 2024 онд 3-аар нэмэгдүүлнэ. | 2021-2023 | - | Тухайн жилд дэд бүтэц нь шийдэгдсэн сум (тоо) | 2020 | 2 | 1 | 2022 онд Эрдэнэдалай сумын төвийн 50 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам, цэвэр усны шугамын барилга угсралтын ажлыг "Сайн констракшн" ХХК гүйцэтгэж 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан. Сайхан-Овоо сумын 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг "Алтайн үндэс" ХХК 1,22 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна. Луус сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг "Бурхант хясаат" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 15 хувьтай байна. | 100 |
| 6.1.1.1 | **Арга хэмжээ:** Шаардлагатай сумдад усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах | 2021-2023 | 1,800 ГХ | Тухайн жилд ашиглалтад орсон сумдын тоо | 2020 | 0 | 1 | Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилттэй "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл"-ийн хүрээнд Эрдэнэдалай сумын төвийн 50 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам, цэвэр усны шугамын барилга угсралтын ажлыг "Сайн констракшн" ХХК гүйцэтгэж 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан. Сайхан-Овоо сумын 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг "Алтайн үндэс" ХХК 1,22 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан. | |
| 6.1.1.2 | Арга хэмжээ: Сумдыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох | 2021-2024 | 148 ОНТ | Тухайн жилд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумдын тоо | 2020 | 6 | 2 | Баянжаргалан, Өндөршил, Луус сумдын ерөнхий төлөвлөгөөг "Сонголт дизайн" ХХК боловсруулж, магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад Дэрэн, Дэлгэрхангай, Өндөршил, Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 400 сая төгрөгийг батлуулсан бөгөөд Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Сонголт дизайн" ХХК, Дэлгэрхангай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Төгс цацраг" ХХК тус тус гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 6.1.1.3 | Арга хэмжээ: Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ажлын зургийг батлуулах | 2021-2022 | - | Тухайн жилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө", ажлын зургийг батлуулах ажлын тоо | 2020 | 0 | 2 | Аймгийн төвийн "Түмний хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн даалгаврыг батлуулан ажлын зургийг "Бес онцгой дизайн" ХХК гүйцэтгэж байна. Нийт 4 га газарт төлөвлөлт хийгдсэн бөгөөд ажлын | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зураг төсвийг 2022 оны 12 дугаар сард хүлээлгэн өглөө. | |
| 6.1.1.4 | Арга хэмжээ: Жишиг гудамж төсөл, тохижилтын ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021-2024 | 200,0 ОНТ | Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 1 | 1 | Аймгийн төвийн багуудад жишиг гудамж байгуулах, дэд бүтэц, ногоон байгууламжийг сайжруулах ажилд 200 сая төгрөгийг ОНХС хөрөнгөнд баталсан. Барилга угсралтын ажлыг "Дундговь-Ус" ОНӨҮГ гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 40 хувьтай байна. | 100 |
| 6.1.1.6 | Арга хэмжээ: Сумдад орон сууцны барилгыг ашиглалтад оруулах | 2021-2024 | 4,800.0 ХХ | Тухайн жилд ашиглалтад орсон орон сууцны тоо | 2020 | 6 | 3 | 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар Сайнцагаан сумын Залуус хороололд 145 айлын 6 орон сууцны барилга ашиглалтад оруулсан. Мөн аймгийн хэмжээнд 110 айлын 5 орон сууцны барилгын ажил үргэлжилж байна. | 100 |
| 6.1.1.7 | Арга хэмжээ: Сайнцагаан, Дэрэн, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах. | 2022-2023 | 216.0 ОНТ | шинээр ашиглалтад орсон барилгын тоо | 2020 | 0 | 2 | 2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Эрдэнэдалай сумын ЗДТГазрын барилгын засварын ажилд 216 сая төгрөг батлан ""Мандал Өргөө Голомт" ХХК гүйцэтгэн 2022 оны 09 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 30 |
| 6.1.1.9 | Арга хэмжээ: Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх. | 2021-2022 | 250,0 УТХО | Буулгасан барилга байгууламжийн тоо | 2020 | 1 | 3 | Тус аймгийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууцны барилгыг буулгаж, дахин төлөвлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна. 2022 онд Сайнцагаан сумын Хүмүүнлэг 3 дугаар сургуулийг буулгаж шинээр 660 суудалтай сургууль спорт заалны барилгын ажлыг "Си Эйч Би Жи Констракшн" ХХК 9,8 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 9 дүгээр сарын байдлаар буулгалтын ажлыг | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүрэн хийсэн. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг "Энх баялаг констракшн" ХХК 2,710 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан, буулгалтын ажлыг хийсэн. Дээрх ажлуудын тухай оны гүйцэтгэл 100 хувьтай байна. | |
| 6.1.1.12 | Арга хэмжээ: Сумдын өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлэх | 2021-2024 | - | Шийдвэрлэсэн маргааны тоо | 2020 | 0 | 18 | Маргаантай байгаа 18 нэгж талбарын маргааныг шийдвэрлэхээр 2022 оны сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан. Дээрх төлөвлөгөөний дагуу 18 маргааныг шийдвэрлэж, холбогдох сумдын Засаг даргын захирамжаар газрыг эзэмшүүлж зөрчлийг арилгасан. | 100 |
| 6.1.1.13 | Арга хэмжээ: Дэлгэрхангай уулын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэх | 2022-2023 | УТХ 6000,0 | Ажлын гүйцэтгэлийн хувь | 2020 | 0 | 60 | Дэлгэрхангай уулын ард сумын төвөөс баруун тийш 4 км агаарын төвлөрсөн эрчим хүч 250квт хүчин чадалтай, 15квт-ын цахилгаан дамжуулах шугам татах ажлын зураг төсвийн ажлыг БЗӨБЦТС –ТӨХК-тай 2022 оны 04 сарын 26 ны өдрөөс 30 хоногийн хугацаатай 6000 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл 30 хувьтай байна. | 50 |
| 6.1.2 | Зорилт: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо 2020 онд 3878 байсныг 2024 онд 4750 болгон нэмэгдүүлнэ. | 2021-2024 | - | Тухайн жилд хамрагдсан иргэдийн тоо | 2020 | 3878 | 4314 | ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоо давхардсан тоогоор 13,440 байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.2.1 | Арга хэмжээ: ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл, арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн тоог нэмэгдүүлэх | 2021-2024 | - | Тухайн жилд байршуулсан мэдээллийн тоо | 2019 | 12 | 12 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл арга хэмжээний мэдээллийг Аймгийн нэгдсэн сайт болон пэйж хуудсаар мэдээлж байна. 2022 онд нийт хүлээн авсан төсөл арга хэмжээ болон гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээг нийт 15 удаа мэдээлсэн байна. | 100 |
| 6.1.2.2 | Арга хэмжээ: Тухайн онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг tusuv-oron nutag.mn сайтад тухай бүр мэдээлэх | 2021-2024 | - | Хэрэгжилтийн хувь | 2019 | 100 | 100 | https://onhs.mof.gov.mn/ сайтад 2022 онд хэрэгжиж буй төсөл арга хэмжээний мэдээллийг 100% оруулан ажиллаж байна. | 100 |
| 48 зорилтын хэрэгжилт | | | | | | | | 92,76% | |
| 195 арга хэмжээний хэрэгжилт | | | | | | | | 92,7% | |

ХЭРЭГЖИЛТИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Н.ДЭЛГЭРМАА

2023 оны 01 сарын 30 өдөр